# ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

**2023-12-14**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт-гэлийн хувь | 2023 оны зорилтот түвшин |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛГО. ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ТАНДАЛТ, СЭРГИЙЛЭЛТ, ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНД ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИЙГ НЭВТРҮҮЛЭХ, СУРГАЛТ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ТАСРАЛТГҮЙ ХАНГАХ** | | | | | | | |
| **ЗОРИЛТ 1. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУСГАЙЛАН ҮҮРЭГ БОЛГОСОН АРГА ХЭМЖЭЭГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ** | | | | | | | |
| **1.1** | Амьсгалын замын синциталь вирусын геномын нуклеотидын дараалал тогтоох шинжилгээний аргачлал нэвтрүүлнэ. | 100 сая төгрөг (Дотоод нөөц) | Олон улсын GISAID мэдээллийн санд байршуулсан шинжилгээний тоо | - | Томуу, Амьсгалын замын синцетиал вирусын бүтэн гений дарааллыг тодорхойлох сургалтанд Австралийн Мелбурн хот дахь VIDRL лабораторид 2023 оны 10 дугаар сард тус төвийн Вирус судлалын лабораторийн 2 мэргэжилтэн, УНТЭ-ийн 1 мэргэжилтэн хамрагдаж ирсэн. 2023 оны 10 сарын 30-наас Амьсгалын замын синцетиал вирусийн бүтэн гений дарааллыг тогтоох шинжилгээний аргачлал нэвтрүүлэх зорилгоор 48 сорьц сонгохоор -70 хөлдөөгчийнд байгаа 2022/2023 оны сорьцод бх-УТ-ПГУ-ийн шинжилгээг хийв. 2023 оны 11 сарын 5 наас бүтэн гений дараалал тогтоох шинжилгээний праймер дарааллыг бэлтгэж, РНХ-гээс сДНХ болгох ажилбарыг хийж дуусгаж nanodrop-1000 багажаар анхан шатны үр дүнг шалгав. Шалгалтаар 32 сорьцод шинжилгээг үргэлжлүүлж болох үр дүн гарсан ба 2023 оны 11 сарын 13-наас дараагийн шат руу орж шинжилгээг хийж байна. | 80% | Эмч, мэргэжилтнүүдийг сургаж, аргачлалыг нэвтрүүлж нутагшуулсан байна. |
| **1.2** | Уушгины бус (нуруу нугас) сүрьеэгийн мэс заслын бэхэлгээт болон нөхөн сэргээх | 290 сая төгрөг (Улсын төсөв) | Амжилттай хийсэн мэс заслын тоо | Мэс заслын сөрөг даралттай өрөөний их | Сүрьеэгийн мэс заслын тасаг нь 2023 онд нурууны бэхэлгээт мэс засал хийх ажлын хүрээнд: | 70% | Уушгины бус (нуруу нугас) сүрьеэгийн мэс заслын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлнэ. | | | засвар дуусч хүлээн авсан. | 1. Эмч мэргэжилтэн бэлтгэх - Мэс заслын эмч Г.Ууганбаяр мэдрэлийн мэс заслын олгох сургалтанд 2021-2022 онд суралцаж төгссөн.<br><br>2. Багаж тоног төхөөрөмж бэлтгэх – Мэс заслын вакум өрөө, C-ARM багажийг бэлтгэсэн. Мөн нурууны бэхэлгээнд хэрэглэгдэх өндөр өртөгт багаж төхөөрөмжийг нийлүүлэх “Orto spain” ХХК-тай гэрээ байгуулж бэлэн байдал хангасан.<br><br>3. УНТЭ - ийн мэдрэлийн мэс заслын тасагтай 2023 оны 05 дугаар сард 2 эмнэлгийн удирдлагын түвшинд гэрээ байгуулсан.<br><br>4. ХӨСҮТ-ийн талаас мэс засал хийхэд бэлэн болсон боловч бэхэлгээ хийлгэх үйлчлүүлэгдийн заалт тохирохгүй байгаа тул бэхэлгээ хийх заалт бүхий тохиолдлыг хүлээж байна. | | бэхэлгээт болон нөхөн сэргээх эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлсэн байна. |
| **1.3** | Албан хаагчдын сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах зорилгоор “Сахилга хариуцлагын гэрээ” байгуулна. | Дотоод нөөц | Зөрчлийн тоо | Гашуун сухайт боомтод томилогдож буй албан хаагчидтай “Сахилга хариуцлагын гэрээ” байгуулж ажилласан. | 2023 онд шинээр ажилд орсон 80 ажилтантай хөдөлмөрийн гэрээ, сахилга хариуцлагын гэрээ байгуулж баталгаажуулсан | 100% | Нийт албан хаагчид гэрээг мөрдөж, сахилгын зөрчилгүй ажилласан байна. |
| **1.4** | Төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулж, | Дотоод нөөц | Ёс зүйн зөрчлийн тоо | 2022 онд ёс зүйн зөрчлийн тоо 5 байсан. | Эрүүл мэндийн яамны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны 2023 оны 09 дүгээр сарын 08-ний өдрийн 19 дүгээр тогтоолоор төвийн дэргэдэх ёс зүйн салбар хороог шинэчлэн батлаж эрүүл мэндийн сайдын 2019 оны 9 дүрээр сарын 14-ний өдрийн А/406 дугаар тушаалаар баталсан эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийг баримтлан | 100% | Төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж, ёс зүйн зөрчилгүй ажилласан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлнэ. | | | | ажиллаж байна.<br><br>Төвийн нийт ажилтнуудад Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” сэдвээр хуулийн зөвлөх н.Нарантуяагаар Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай” А/406 дугаар тушаал болон эмнэлгийн ажилтны ёс зүйн алдаа, сургамж сэдвээр ЭМЯ-ны ёс зүйн Хяналтын хорооны дарга Д.Оюунбилэг, өргөдөл гомдол хүлээн авах хэсгийн ахлагч Ш.Оюунчимэг нараар 2 өдрийн сургалт зохион байгуулав. | | |
| **1.5** | Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ. | Дотоод нөөц | Төлөвлөгөөний биелэлтийн хувь | Жил бүр төлөвлөгөө батлуулан, хэрэгжүүлэн ажилладаг. | Байгууллагад авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг арилгах, авлига, ашиг сонирхолын зөрчил, хүнд суртал, шударга бус байдал гаргахгүй байх ажлыг зохион байгуулж 5 бүлэг 12 заалт бүхий авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлт 97%-тай байна.<br>2023 оны хагас жилийн байдлаар Засгийн газраас зохион байгуулж буй “Шүүр” ажиллагаа, “Шүгэл” ажиллагаа, АТГ-с зохион байгуулсан “Авлигын эсрэг нэгдье аян”, “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” аян, Эрүүл мэндийн салбарын албан тушаалтнуудад “Албан тушаалтанд хориглолт, хязгаарлалт, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдэгдэл, тайлбар гаргах, авлигын гэмт хэрэг, түүний хор уршиг болон авлигын эсрэг хууль тогтоомжийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх тухай” сургалт, “Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг, анхаарах зарим асуудлууд” сэдэвт сургалт, “Авлигын гэмт хэргийн тухай ойлголт” сэдэвт сургалт, ЭБАТ-сургалтад тус тус хамрагдсан.<br>Авилгын эсрэг соён гэгээрүүлэх, авлигаас | 97% | Төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсэн байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | урьдчилан сэргийлэх чиглэлээр авлигын эсрэг сургалт, сурталчилгааг зохион байгуулах үндэсний сургагч багшаар төвийн ЭБАТ суралтад хамрагдсан сургагч багш болсон. | | |
| **1.6** | Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах утас, цахим хаягийг ил тод байрлуулах, ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу хүргүүлнэ. | Дотоод нөөц | Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын хувь | Тухай бүр шийдвэрлэн ажилласан. | Тус төв нь иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг 11-451466 утас, байгууллагын цахим хуудас, амбулатори болон хэвтүүлэн эмчлэх тасгуудад QR кодыг ил тод байршуулан, иргэдээс ирсэн санал хүсэлтийг шуурхай авч шийдвэрлэн ажиллаж байна.<br>2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 88 өргөдөл, гомдол ирснээс<br>- Шийдвэрлэж хариу өгсөн-82<br>- Хугацаа болоогүй 6 байна.<br>Шийдвэрлэлтийн байдал 95,4%<br>Ирсэн өргөдөл, гомдлыг агуулгаар нь авч үзвэл:<br>- Эмчилгээ, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой - 49<br>- Эмч, ажилчдын мэргэжлийн чадвар, харилцаа, хандлага, ёс зүйтэй холбоотой – 14<br>- Эмчилгээний төлбөр, дэмжлэг хүсэхтэй холбоотой – 2<br>- Улирал, цаг үеийн шинжтэй зонхилж байгаа асуудал - 4 | 95,4% | Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг хүргүүлсэн байна. |
| **1.7** | Эмнэлгийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлыг хангах чанарын хяналтын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ. | Дотоод нөөц | Зөрчлийн тоо | - | 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар эмнэлгийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлыг хангахаар 29 чиглэлээр 126 удаа хяналт хийхээр төлөвлөгөө гарган батлуулсан. Үүнээс 25 чиглэлээр 97 удаагийн хяналт үнэлгээг хийсэн. Хяналт үнэлгээний төлөвлөгөөний биелэлт 89%. Хяналт үнэлгээг чиглэл тус бүрээр урьдчилан боловсруулсан хяналтын хуудсаар үнэлсэн. Нийт 117 хяналтын хуудас боловсруулж ерөнхий захирлаар батлуулан ажиллаж байна. | 89% | Төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсэн байна. |
| **1.8** | Төвийн үйл ажиллагааны дотоод хяналтын төлөвлөгөө | Дотоод нөөц | Зөрчлийн тоо | - | Төвийн үйл ажиллагааны дотоод хяналтын төлөвлөгөөг боловсруулж төвийн ерөнхий захирлаар батлуулан | 80% | Төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ. | | | | ажиллаж байна.<br>Төлөвлөгөөнд заагдсан 21 ажлаас 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн бадлаар төлөвлөгөөний биелэлт 80%-тай байна. | | байна. |
| **1.9** | Үйлчилгээний соёлыг сайжруулах удирдамж, зааврыг боловсруулан батлуулж, мөрдөнө. | Дотоод нөөц | Хэрэгжилтийн хувь | - | 1. “Үйлчлүүлэгчээ сонсож, хүнд сурталгүй үйлчилье” уриан доор ХӨСҮТ-өөр үйлчлүүлж буй үйлчлүүлэгч нараас сэтгэл ханамжийн судалгааг QR code уншуулж цахимаар авч, Төвийн ЭБАТ Ж.Баярсайхан, дотоод аудитор Д.Оюунномин, Чанарын албаны лавлагаа үйлчилгээ хариуцсан ажилтан Б.Хоролгарав нар хүлээн авах яаралтай тусламжийн тасгаар үйлчлүүлж буй үйлчлүүлэгч, амбулаторийн тасгаар үйлчлүүлж байсан манай улсын иргэдээс гадна АНУ, Австрали улс, Бүгд Найрамдах Филиппин улсын иргэдээс ажилтны харилцаа, хандлага, үйлчлүүлэхэд учирч буй саад бэрхшээлийн талаар санал хүсэлтийг нь сонсож холбогдох албан тушаалтанд уламжлав.<br>2. Тус төвөөр үйлчлүүлэгч нарт эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхэд анхаарах ёс зүй, харилцаа хандлага, соёлын талаар 2 видео сурталчилгаа хийж байгууллагын цахим сайтад байршуулав.<br>3. Үйлчилгээний соёлыг сайжруулах удирдамж, заавар боловсруулах шатандаа явагдаж байгаа бөгөөд удирдамж зааврын боловсруулалат 80%-тай байна, | 80% | Удирдамж, зааврыг мөрдөн, алдаа зөрчилгүй ажилласан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1.10** | Төвийн гадна болон дотор хаягжилт (гадна байрны хаяжилт, алба, тасаг нэгж, өрөөний хаягжилт, дуугүй хөтөч, орны тэмдэглэгээ, гадна гэрэлтүүлэг)-ыг хийнэ. | 100 сая төгрөг (Дотоод нөөц) | Гомдлын тоо | Амбулаторийн хэсгийн хаягжилтыг хийсэн. | Тус төв нь нийт 9 га газар, 31 барилга байгууламжтай бөгөөд нийт барилгын гадна хаягжилт, алба тасгийн байршил заасан хаягжилт, үйлчлүүлэгч болон ажилчдад мэдээлэл өгөх зорилготой мэдээллийн самбарыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:<br>1. Гадна хаягжилт нийт 30 барилгад хийгдсэн байна.<br>2. Тасаг алба бүрийн дотор талд давхарын мэдээлэл байршуулсан байна.<br>3. Тасаг алба бүрийн мэдээллийн самбар, үйлчлүүгэчдэд зориулсан тоон мэдээллээр самбарыг тус бүр байрлуулсан байна.<br>4. Тасаг бүрийн палатны дугаарлалтыг хийж гүйцэтгэсэн байна.<br>5. Төвийн төв хаалганд Барилга байгууламжийн мэдээлсэн самбар байршуулсан байна. | 100% | Үйлчлүүлэгчид төөрөгдөл, бухимдалгүй үйлчлүүлсэн байна. |
| **ЗОРИЛТ 2. ЭРҮҮЛ МЭНДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ БОЛЗОШГҮЙ ЦАР ТАХАЛ, ШИНЭ БОЛОН СЭРГЭЖ БУЙ ХАЛДВАР, БУСАД ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ТАНДАЛТ, СЭРГИЙЛЭЛТ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ** | | | | | | | |
| **2.1** | Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | Улсын төсөв, ЭМД-ын сан, Олон улсын төсөл, хөтөлбөр | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/253 дугаар тушаалаар “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө” батлагдсан. | Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн тайлан ЭМЯ-нд хүргүүлсэн бөгөөд хэрэгжилт 85 хувьтай байна. | 85% | Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2023 онд төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна. |
| **2.2** | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний алдааны шалтгаан, нөхцөл байдлыг тодорхойлох үнэлгээ (Roote cause situation analyze)-г хийнэ. | 40 сая төгрөг (Олон улсын байгууллага) | Үнэлгээний тайлан | - | Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/05 дугаар тушаалын дагуу Эрүүл мэндийн яам, ХӨСҮТ, ЗӨСҮТ эмч, судлаач нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс 2023 оны 01 дүгээр сарын 10- | 50% | Үнэлгээний үр дүнгээс гарсан зөвлөмжийг холбогдох эрүүл мэндийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ны өдөр хүртэл Сүхбаатар аймагт батлагдсан удирдамжийн дагуу ажилласан.<br><br>Ажлын хэсгийн бүрэлдэхүүн аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн дарга, эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга, Эмнэлэгийн тусламж хариуцсан мэргэжилтэн, эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч нарын бүрэлдэхүүнтэй уулзаж, ажлын хэсгийн зорилго, удирдамжийг танилцуулан үүссэн нөхцөл байдлын талаарх мэдээллийг Эрүүл мэндийн газрын холбогдох удирдлагуудаас авч, танилцан хамтран ажиллалаа.<br>Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлэгт галзуугийн эсрэг вакцин хийлгэхээр ирсэн иргэдэд сүрьеэгийн эсрэг БЦЖ вакциныг сольж хийсэн асуудалд дэмжлэгт хяналт хийн, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж хүргүүлсэн.<br>Эмнэлгийн тусламж, үйлчилгээний алдааны шалтгаан, нөхцөл байдлыг арилгах үнэлгээ IV улиралд хийхээр төлөвлөж, ажлын хэсэг байгуулан бэлтгэл ажлыг хангаж байна. Ажлын хэсэг 12 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд удирдамжын дагуу хяналт, үнэлгээг хийнэ. | | байгууллагад хүргүүлсэн байна. |
| **2.3** | Олон улсын эрүүл мэндийн дүрмийн хаягаар мэдээлдэг халдварт өвчний мэдээллийг хүлээн авах, түгээх, эрсдэлийг үнэлэх журам боловсруулан батлуулж, мөрдөнө. | Дотоод нөөц | Батлагдсан журам | Үйл ажиллагаа хийгдэж байгаа боловч батлагдсан журам байхгүй. | "Олон улсын эрүүл мэндийн үндэсний зохицуулагчийн ажиллах журам" боловсруулан, байгууллагын удирдлагууд болон мэргэжилтнүүдээс санал авч, хянагдан, Ерөнхий захирлын 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/174 тоот тушаалаар батлагдсан. Энэ журам нь 9 хэсэгтэй ба үүнд үндэслэл, хийгдэх үйл ажиллагаа, үндэсний зохицуулагчийн үндсэн эрх, чиг үүрэг, харилцаа холбоо, хариу арга хэмжээ, хариуцлагыг заасан байдлаар боловсруулагдан батлагдсан | 100% | Батлагдсан журмыг мөрдөж, үйл ажиллагааны хэвийн байдлыг ханган ажилласан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна. | | |
| **2.4** | Салбарын болон салбар хоорондын мэргэжилтнүүдэд зориулсан “Эрсдэлийн үнэлгээг хийх тухай” гарын авлагыг боловсруулж гаргана. | 3 сая төгрөг (ДЭМБ) | Шинээр боловсруулж гаргасан гарын авлага | - | Салбарын болон салбар хоорондын мэргэжилтнүүдэд зориулсан “Эрсдэлийн үнэлгээг хийх тухай” гарын авлагыг Монгол Улсын Шадар сайдын 2023 оны А/28 тушаалаар батлагдсан аргачлалын дагуу боловсруулан бэлэн болгосон. | 100% | Гарын авлага гаргаж, эрсдэлийн үнэлгээнд ашигласан байна. |
| **2.5** | Үйл явдалд суурилсан тандалтын тогтолцоог аймаг, улсын түвшинд сайжруулах, хэвлэлийн мэдээллийг шүүж нийгмийн эрүүл мэндэд ноцтой үйл явдлыг илрүүлэх тандалтыг хийнэ. | 35 сая төгрөг (ДЭМБ) | Бэлтгэгдсэн мэргэжилтний тоо, тандалтын тайлан | - | Нийгмийн эрүүл мэндэд ноцтой байж болзошгүй үйл явдлын мэдээллийг үндэсний хэмжээнд хандалт хамгийн өндөр 20 хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээс өдөр бүр тогтмол шүүж байна. 2023 онд үйл явдлын байж болзошгүй 170 (дотоод 154, гадаад 16) дохиог илрүүлж, шаардлагатай арга хэмжээг авсан.<br><br>21 аймаг, 9 дүүргийн ЭМГ, ЭМТ-ийн нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга, тандалтын нэгжийн эмч нарыг үйл явдалд суурилсан тандалтын чиглэлээр сургалтад хамруулсан. | 100% | Нийт 10 хүнийг бэлтгэж, тандалтыг хийж эхэлсэн байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.6** | Хүн, малд B.mallei халдварын тархвар судлалын шинжилгээний үр дүнд дүн шинжилгээ хийж, халдвар дамжих эрсдэл болон түүний эмгэг төрүүлэгч байдлыг үнэлнэ. | Дотоод нөөц | Үнэлгээний тайлан | - | “САТРЕПС” төслийн хүрээнд Сэлэнгэ, Өмнөговь, Дундговь, Хэнтий, Дорнод, Сүхбаатар зэрэг 6 аймгийн 22 сумын 87 малчин болон Налайх дүүргийн Ундрах хайрхан, Гомбохайрхан зэрэг 2 мал нядалгааны газрын 3 ажилчдаас тусгайлан боловсруулсан 12 асуумж бүхий судалгаа авч, 2 мал нядалгааны газарт үнэлгээ хийсэн.<br><br>Нийт судалгаанд хамрагдагсдын 30% нь адууны ям өвчний талаар мэддэг, 5.7% нь өөрийн адуун сүргээ ям өвчний шинжилгээнд хамруулсан, 38.3% нь малдаа шинж тэмдэг илэрсэн тохиолдолд ЭМБ-д ханддаг байна.<br><br>УБ хотод Эмээлт, Найлайх дүүрэгт байрлах мал нядалгааны газруудаас нийт 78 сорьц цуглуулж нян судлал болон молекул биологийн шинжилгээ хийж, Burkholderia төрлийн 25 өсгөвөрийг гарган авсан. Үүний 7 нь B.mallei байна. | 80% | Мал, хүний хооронд B.mallei халдвар дамжих эрсдэл болон эмгэг төрүүлэгчийн үнэлгээг хийсэн байна. |
| **2.7** | Тэмбүүгийн халдвар хамгийн өндөр бүртгэгдсэн эрсдэлт бүлэг болох ШШГЕГ-ын харьяа хорих ангийн хоригдлуудад тэмбүү, ХДХВ-ийн халдварын илрүүлэг, үзлэг хийж, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулна. | 35.9 сая төгрөг (Глобаль сан) | Шинжилгээнд хамрагдсан хоригдлын хувь | ШШГЕГ-ын харьяа хорих 21 ангийн нийт 4139 хоригдол хамрагдсан. | 2023 онд төвлөрсөн ШШГЕГ-ын харьяа 20 хорих ангийн 4057 сэжигтэн, хоригдогч, хоригдлуудыг ХДХВ/ДОХ, тэмбүү илрүүлэх шинжилгээнд хамруулахад 782 тэмбүүгийн халдвар илрүүлсэн бөгөөд ХӨСҮТөвийн ДОХ бэлгийн замын нэгдсэн лабораторид тэмбүүгийн идэвхжилийг үзүүлэхээр явуулсан. Үүнээс идэвхжил өндөртэй-187 тохиолдол илэрсэнийг эмчлэн, хянаж байгаа ба тэдгээрийн дунд ХДХВ халдвар бүртгэгдээгүй байна. | 100% | ШШГЕГ-ын харьяа 6 хорих ангийн хоригдлуудыг бүрэн хамруулсан байна. |
| **2.8** | “ДОХ-ын тархалтын загварын дүн шинжилгээ” тооцоолол 2022-ыг хийнэ. | 1 сая төгрөг (ДЭМБ) | ХДХВ-ийн халдварын тархалтын тооцооллын тайлан | Монгол Улс дахь ХДХВ-ийн халдварын тархалтын тооцоолол 2021 тайлан гарсан. | Тус алба нь 2010 оноос НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн хөтөлбөрийн “Дэлхийн ДОХ-ын асуудлаарх хяналт шинжилгээний тайлан”-гийн тоон үзүүлэлтүүд, ХДХВ, ДОХ-ын Үндэсний зарцуулалтын байдлын үнэлгээ, 2018 оноос ХДХВ, ДОХ-ын тархалтын загварчлалын тооцооллыг бие даан хийж байна. ДОХ-ын тархалтын загварчлалыг тооцохдоо тусгай | 100% | Монгол Улс дахь ХДХВ-ийн халдварын тархалтын тооцоолол 2022-ын тайлан гарч, зөвшилцөх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | программын тусламжтайгаар түүнд ашиглах статистикийн бүх мэдээллийн эх сурвалжийг үнэлж, параметрүүдийг тооцож мэдээлдэг. Энэхүү мэдээлэлд үндэслэн нотолгоонд суурилсан шийдвэрийг гаргаж, эрдэм шинжилгээ судалгааны ажлууд хийгддэг.<br><br>Тус тооцооллыг хийх үйл ажиллагааны хүрээнд албаны 1 их эмч Тайланд улсад очиж, шинэ аргачлалд суралцан 2023 оны 2 сард тооцооллыг тооцон гаргаж, үр дүнг холбогдох талуудтай зөвшилцөн илгээсэн. Уг тооцоолын үр дүнд үндэслэн цаашид ХДХВ/ДОХ-ын чиглэлээр хийх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байна. Уг тооцоолын үр дүнд үндэслэн цаашид ХДХВ/ДОХ-ын чиглэлээр хийх үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ. | | уулзалтыг хийсэн байна. |
| **2.9** | Үндэсний хэмжээнд хийгдэж байгаа сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтийн тайланг нэгтгэж, эргэн мэдээлэл хийнэ. | Дотоод нөөц | Илрүүлэлтийн тайлан | Сар бүрийн тайлан нэгтгэл, эргэн мэдээлэл хийгддэг. | • Аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төвд ХӨСҮТ-ийн ерөнхий захирлын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн “Сүрьеэгийн илрүүлэлтийн төлөвлөгөө гаргах, хэрэгжилтийг хангах тухай” 3-3/234 тоот албан тоотыг хүргүүлж, сүрьеэгийн илрүүлэх үзлэгт хамруулбал зохих эрсдэлт бүлгийн жагсаалтыг 2023 оны 1-р улиралд багтаан авах талаар тусган оруулсан. Мэдээ тайланг хүлээн авч нэгтгэх ажил хийгдэж байна.<br>• 2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар сүрьеэгийн эрсдэлт бүлгийн судалгааг 10 нэгжээс ирүүлж, хэрэгжилт 33,3%-тай байна. Судалгааг нэгтгэхэд нийт 28,867 эрсдэлт бүлгийн хүн амыг тодорхойлон илрүүлсэн байна.<br>• 2023 оны эхний 9 сарын байдлаар сүрьеэгийн эрсдэлт бүлгийн 33,363 хүнийг үзлэг идэвхтэй илрүүлэлтэд | 90% | Сар бүрийн тайлан нэгтгэж, эргэн мэдээллийг хийсэн байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамруулж, үүнээс 2428 сүрьеэтэй байж болзошгүй тохиолдлоос сорьц цуглуулж, сүрьеэтэй 208 тохиолдлыг илрүүлж эмчилгээнд хамруулсан.<br>• Налайх дүүргийн 8-р хороо, Баянгол дүүргийн 23-р хороо, БГД-ийн 13 хороо, СЭМҮТ, Энэрэл эмнэлэг зэрэг 5 байгууллагууд зохион байгуулж буй идэвхтэй илрүүлэлтийн талбарт очиж, дэмжлэгт хяналт хийж, шалгуур хуудасны дагуу үнэлж зөвлөгөө өгч ажилласан. Дундаж биелэлт 90% байв. | | |
| **2.10** | Сүрьеэгийн далд халдварын эмчилгээний хамралтад тогтмол хяналт хийж, хавьтлын тайланг гаргана. | Дотоод нөөц | Далд халдварын эмчилгээний хамрагдалтын хувь | Далд халдварын эмчилгээнд 500 хүнийг хамруулсан. | 2023 оны эхний 11 сарын байдлаар сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээнд нийт 591 тохиолдол эмчилгээнд хамрагдсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 19,7%-иар өссөн. | 90% | Далд халдварын эмчилгээнд хамрагдалт өмнөх оноос 60 хувиар нэмэгдсэн байна. |
| **2.11** | НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн хөтөлбөрийн тайлан (Дэлхийн ДОХ-ын хяналт, шинжилгээ үнэлгээний тайлан)-г боловсруулж, хүргүүлнэ. | 2 сая төгрөг (ДЭМБ) | Хөтөлбөрийн тайлан | Жил бүрийн эхний 2 улиралд үнэлгээний тайлан гаргаж хүргүүлдэг. | НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн хөтөлбөрийн “Дэлхийн ДОХ-ын хяналт үнэлгээ”-ний тайланд Монгол Улсаас илгээх тайланг жил бүрийн эхний улиралд багтаан илгээдэг. Тус тайлан нь БЗДХ, ХДХВ/ДОХ-ын өвчлөл, эмчилгээ, оношилгоо, урьдчилан сэргийлэлт болон бусад холбогдох тоон мэдээллийн талаар нийт 8 бүлэг 119 дэд бүлэг бүхий 500 гаруй асуулт, мөн үндэсний үүрэг амлалт бодлогын орчны талаар 2 бүлэг 260 гаруй асуултуудаас бүрдсэн ба бусад хамаарал бүхий үзүүлэлтүүдийг тооцоолон гаргасан. Уг тайланг тус алба нь Монгол Улсыг төлөөлөн явуулдаг учир үр дүнг ЭМЯ, хамтран ажиллагч олон улсын болон ТББ-ын шийдвэр гаргагч нартай зөвшилцөн, саналыг тусган 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр цахимаар илгээсэн. | 100% | Дэлхийн ДОХ-ын хяналт, шинжилгээ үнэлгээний тайланг Монгол Улсаас боловсруулж, хүргүүлсэн байна. |
| **2.12** | НҮБ-ийн Хүүхдийн сан, ДЭМБ-д | Дотоод нөөц | Үйл ажиллагааны тайлан | Жилд 1 удаа, 3 төрлийн тайлан | НҮБ-ийн Хүүхдийн сан, ДЭМБ-д дархлаажуулалтын үйл ажиллагааны 2022 | 100% | Дархлаажуул алтын үйл |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дархлаажуулалтын үйл ажиллагааны 2022 оны тайлан (WHO-Joint report, Polio Progress report, Measles elimination report)-г боловсруулж, хүргүүлнэ. | | | хүргүүлдэг. | оны тайлан (WHO/UNICEF-Joint report)-г цахимаар нэгтгэн 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр буюу заасан хугацаанд нь багтаан илгээсэн.<br><br>Халдварт саа өвчнийг устгасан байдлаа хадгалж буй талаарх тайлан, Улаанбурхан өвчнийг эрс бууруулан устгах чиглэлд 2022 онд хийсэн ажлын бичмэл тайланг 2023 оны 8, 10 дугаар саруудад тус тус ДЭМБ-ын НДББ-д илгээсэн. (Polio Progress report, Measles elimination report) | | ажиллагааны 2022 оны тайланг боловсруулж, хүргүүлсэн байна. |
| **2.13** | Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолыг шинэчлэн батлуулна. | - | Батлагдсан үндэсний товлол" | Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолыг боловсруулж, Дархлаажуулалтын зөвлөлийн хорооны хурлаар хэлэлцүүлсэн. | УИХ-ын чуулганы 2023 оны 10 дугаар сарын 27-ны хурлаар дархлаажуулалтын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг хэлэлцүүлж, дараах нэмэлтийг оруулж батлуулсан.<br>Дархлаажуулалтын хуулийн **10 дугаар зүйл. Заавал хийх дархлаажуулалт**<br>10.1. Заавал хийх дархлаажуулалтад сүрьеэ, халдварт саа /полиомиелит/, В вируст гепатит, сахуу, хөхүүл ханиад, татран, улаанбурхан, В хэв шинжийн хемофилюс инфлюенза нянгийн халдвар, А вируст гепатит, пневмококк, хүний папиллома вирусийн халдвар, гахай хавдар, улаануудын эсрэг сэргийлэх тарилга орно.<br>*<u>/Энэ хэсэгт 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./</u>*<br>**Мөн "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2023 оны 11 сарын 16 өдрийн №42 дугаарт нэмэлт өөрчлөлт хэвлэгдэн гарсан.**<br>Дархлаажуулалтын үндэсний товлолыг шинэчлэн боловсруулж, төслийг Засгийн газарт өргөн барихаар бэлтгэж Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. Яамдуудаас санал авхаар хүргүүлсэн.<br>4 дүгээр улиралд батлуулахаар төлөвлөгдсөн. | 100% | Заавал хийх дархлаажуулалтад хамрагдах хүүхдийн нас, цаг хугацааны тов бүхий үндэсний товлолыг Засгийн газрын тогтоолоор батлуулсан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.14** | Улсын хэмжээнд вакцин, биобэлдмэл, дагалдах хэрэгсэл, хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийг тухай бүр хүлээн авч, вакцин, биобэлдмэлээр тасралтгүй хангана. | 23 тэрбум төгрөг (Улсын төсөв, Олон улсын хандив) | Шинээр хангасан хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж, вакцин биобэлдмэлийн тоо | Улсын хэмжээнд шаардлагатай товлолын болон тархвар судлалын заалтаар хийх вакцин, дагалдах хэрэгслийн төлөвлөлт хийж, захиалга хийдэг. | Улсын хэмжээнд Засгийн газрын хөрөнгөөр заавал хийх үндэсний товлолын болон тархвар судлалын заалтаар хийгдэх 13 төрлийн 17,489,730.000.00 төгрөгийн өртөг бүхий 1,891,000 тун вакцин НҮБ-ын хүүхдийн сангаар дамжуулан, тархвар судлалын заалтаар хийгдэх болон улсын фондын 16 нэр төрлийн 2,417,583,760 төгрөгийн өртөг бүхий 113,590 хүн тун вакцин, биобэлдмэлийг Эрүүл мэндийн яамаар дамжуулан авах асуудлыг “вакцин, төлөвлөлт зохицуулалтын хороо”-гоор хэлэлцүүлэн, шийдвэрлүүлж, нийт 23 тэрбум төгрөгийн үнэ бүхий вакцин биобэлдмэл, зүү тариур, аюулгүй хайрцгийг захиалсан.<br>2023 оны эхний 10 сарын байдлаар Засгийн газрын хөрөнгөөр заавал хийх үндэсний товлолын болон тархвар судлалын заалтаар хийгдэх 13 төрлийн 15,273,844.042.00 төгрөгийн өртөг бүхий 1,891,000 тун вакцин, биобэлдмэл дагалдах хэрэгслийг НҮБ-ын хүүхдийн сангаар дамжуулан, тархвар судлалын заалтаар хийгдэх болон улсын фондын 6 нэр төрлийн 1,195,727,750 төгрөгийн өртөг бүхий 44,690 хүн тун вакцины холбогдох бичиг баримтыг бүрдүүлэлтийг хийж хүлээн авсан.<br>Нэмэлт дархлаажуулалтанд хэрэглэгдэх Улаанбурхан, улаануудын эсрэг 570,000 хүн тун вакциныг хүлээн авсан.<br><br>– Вакцин, дагалдах хэрэгсэл хүлээн авсан тухай бүр бичиг баримтын бүрдүүлэлтийг хийж, вакцин хүлээн авсан тухай мэдээлэх хуудсыг хүргүүлж, улсын хэмжээнд вакцин биобэлдмэлээр эрүүл мэндийн байгууллагыг тасралтгүй хангаж, дархлаажуулах үйл ажиллагааг зохион | 100% | Вакцин, биобэлдмэл, дагалдах хэрэгсэл, хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн тасалдал үүсээгүй байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулж байна. | | |
| **2.15** | Шинэ вакциныг үе шаттай нэвтрүүлнэ. | 2.2 тэрбум төгрөг (Улсын төсөв, Олон улсын хандив) | Хамрагдалтын хувь | Хүний папиллома вирусийн эсрэг вакциныг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд шаардлагатай вакцины тов, төлөвлөлт, төсвийн тооцоог хийж, Дархлаажуулалтын зөвлөлийн хороогоор хэлэлцүүлж батлуулсан. | ЭМС-ийн 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/306 тоот “Хавдрын эсрэг арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” тушаалд тусгагдсанаар 2023 оноос эхлэн хүний папиллома вирусийн эсрэг вакциныг үе шаттай нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд шаардлагатай вакцины тов, төлөвлөлт, төсвийн тооцоог хийж Дархлаажуулалтын зөвлөлийн хороогоор хэлэлцүүлж 11 настай хүүхдүүдийг дархлаажуулахад шаардлагатай 90,000 хүн тун ХПВ-ийн эсрэг вакцины захиалгыг НҮБ-ын Хүүхдийн санд хүргүүлэн хүлээн авсан.<br><br>Дархлаажуулалтын тухай хуулинд заавал хийх товлолт вакцины нэр төрөлд багтаан батлуулсан. Засгийн газрын тогтоолоор товлол, хийх насыг батлуулахаар тогтоолын төслийг боловсруулж, хүргүүлсэн.<br><br>ВДГА-аас шинэ вакцин нэвтрүүлэх үеийн техникийн дэмжлэг авахаар ЭМЯ, ДЭМБ, ХӨСҮТ хамтран цахим уулзалт хийсэн үүнд ХПВ-ийн вакциныг Монгол улсад нэвтрүүлэх явц, цаашид хийх үйл ажиллагааны талаар зөвшилцөж, шинэ вакцин нэвтрүүлэхэд олгодог үйл ажиллагааны дэмжлэг авах хүсэлтийн эхний төслийг бичиж ВДГА-д эхний байдлаар илгээсэн.<br><br>Хүний папиллома вирусийн эсрэг вакциныг сайн дурын үндсэн дээр хийх хүрээнд 2023 онд 10 000 хүн тун вакциныг захиалан, хүлээн авч, эхний 11 сарын байдлаар 1045 хүн тун вакцинд сайн дураар хамруулсан байна. | 100% | Хүний папиллома вирусын дархлаажуулалтад хамрагдах 11 насны хүн амын 75 хувьд хүргэсэн байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.16** | Дархлаажуулалт бүхий халдварт өвчний тандалтыг улсын хэмжээнд зохион байгуулах, “Халдварт саа өвчнийг устгасан байдал”-аа хадгалах, улаанбурхан өвчний лабораторид суурилсан тандалтыг хийнэ. | 120 сая төгрөг (Улсын төсөв, Олон улсын хандив) | Дархлаажуулалт бүхий халдварт өвчний тохиолдлын тоо, шалгуур үзүүлэлтийн биелэлт | Дархлаажуулалт бүхий халдварт өвчний тандалтыг улсын хэмжээнд зохион байгуулахад мэргэжил арга зүйгээр хангасан. | Дархлаажуулалт бүхий халдварт өвчний тандалтыг улсын хэмжээнд хам шинжийн болон сэжигтэй тохиолдлын тандалтыг хийж байна. Эхний 11 сарын байдлаар халууралт тууралттай хам шинжийн тандалтын мэдээгээр 2427 тохиолдол мэдээлэгдэж тандалт судалгааг хийсэн.<br><br>2023 оны эхний 11 сард улаанбурханы сэжигтэй 96 тохиолдолд тархвар зүйн тандалт судалгаа хийж цусны сорьц цуглуулж, улаанбурхан улаануудын өвөрмөц IgM илрүүлэх шинжилгээ хийхэд улаанууд өвчний нэг тохиолдол лабораториор батлагдсан. Нийт 96 мэдээлэгдсэн тохиолдлыг тохиолдлын жагсаалтад оруулан ДЭМБ-ын НДББ-д бодит цаг хугацааны програмд шивж оруулан мэдээлсэн.<br><br>Улсын статистик мэдээнд лабораториор батлагдсан улаанууд нэг тохиолдлын мэдээг оруулсан.<br><br>- **Улаанбурхан, улаануудын тандалтыг эрчимжүүлэх хүрээнд** Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан улаанбурхан өвчний нөхцөл байдал, тандалт, хэрэгжүүлэх арга хэмжээ, дэгдэлтийн үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр цахим сургалтанд аймаг, дүүргийн өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч ажилтанууд 100 гаруй хүнд хийсэн.<br>- ЭМЯ, ХӨСҮТ, ДЭМБ хамтран **“Дархлаажуулалтын хөтөлбөрийн хэрэгжилт, улаанбурхан, улаанууд өвчний тандалт, хариу арга хэмжээ”** сэдэвт сургалтыг 2023 оны 4 сарын 19-нд зохион байгуулсан. Сургалтанд 21 аймаг, 9 дүүргийн эрүүл мэндийн | 100% | Улаанбурхан өвчний лабораторийн тандалтыг тогтмол хийсэн байна. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газрын нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга, дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн, халдвар судлаач, нэгдсэн эмнэлгийн чанарын менежер, хүүхдийн эмч, төрөлжсөн эмнэлэг, нийслэлийн хувийн хэвшлийн хүүхдийн эмнэлгүүдийн төлөөлөл нийт **240 хү**н хамрагдсан байна.<br>- ЭМЯ, ХӨСҮТ, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран **“Дархлаажуулалтын хөтөлбөрт гео орон зайн мэдээлэл болон гео технологи ашиглах нь”** сэдэвт сургалтыг 4 сарын 20-21 өдрүүдэд зохион байгуулсан. НҮБХС-ийн GIS geo-enabling буюу эрүүл мэндийн мэдээлэлд орон зайн өгөгдөл мэдээлэл технологийг ашиглах чиглэлээр ажилладаг зөвлөх Steeve Ebener-тай хамтран зохион байгуулсан. Сургалтанд 21 аймаг, 9 дүүргийн эрүүл мэндийн газрын нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга, дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн, АШУИС-ийн багш, НЭМҮТ-ийн мэргэжилтэн, бусад байгууллагын нийт **80 хүн** хамрагдсан.<br>- ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын алба, Сувилахуйн алба хамтран **“Зонхилон тохиолдох халдварт өвчний сувилахуйн тусламж үйлчилгээ, тархвар судлалын вакцинжуулалт**” сэдэвт сургалт, эрдэм шинжилгээний хурлыг 2023 оны 05 сарын 17-18–ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтанд 21 аймаг, 9 дүүргийн ЭМГ-ын вакцины хүйтэн хэлхээ хариуцсан бага эмч, нэгдсэн эмнэлгийн халдварт, яаралтай тусламжийн тасаг болон ХӨСҮТ-ийн сувилагч нар нийт 180 гаруй хүн хамрагдлаа.<br>- **“Халдварт өвчин ба эрсдэлийн харилцаа холбоо”** сэдэвт | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн цэцэрлэг, ЕБС-ийн эмч, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт зориулсан цахим сургалтад “Тарилгаар сэргийлэгддэг халдварт өвчин ба дархлаажуулалт” сэдвээр 618 хүнд мэдээлэл хийсэн.<br>- Баян-Өлгий аймагт “Тарилгатай халдварт өвчний тандалт”, “Вакцин менежмент”, “Коронавируст халдвар (ковид-19)-ын эсрэг вакцины дархлаажуулалт” сэдэвт сургалт, дэмжлэгт хяналт, мэдээ, мэдээллийн чанарт үнэлгээ хийсэн.<br><br>Мөн улаанбурхан улаануудын тандалтыг эрчимжүүлэх хүрээнд ДЭМБ-ын НДББ, ТХӨ хариуцсан зөвлөх, Доктор Чун-Вон Ли 2023 оны 2 болон 5-р саруудад 2 удаагын айлчлал хийх ажилласан. **Айлчлалын зорилго:**<br><br>- Монгол улс Улаанбурхан өвчний тахал тархалтыг таслан зогсоосныг эргэн баталгаажуулахад шаардлагатай үйл ажиллагааны зураглал гаргах,<br>- Улсын хэмжээнд төрөлхийн улаануудын хам шинжийн тандалтын эргэмж судалгаа хийх, судалгааны арга зүй боловсруулах, судлаачдыг сургах сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах ажлыг АНУ-ын ӨХСТ, ХӨСҮТ, ЭХЭМҮТ, ДЭМБ, ЭМЯ-тай хамтран зохион байгуулсан.<br><br>Дэгдэлтээс сэргийлэх хүрээнд “Улаанбурхан өвчнөөс хамтдаа сэргийлье” уриан дор 10 сартайгаас 8 насны хүүхдийг улаанбурхан, улаанууд өвчний эсрэг вакцинаар нэмэлт дархлаажуулалт зохион байгуулах**,** дархлаажуулалтын 10 хоног зохион байгуулахтай холбоотой бэлтгэл | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажлыг хангах хүрээнд:<br>- Дархлаажуулалтын зөвлөх хорооны ээлжит хурлыг 2023 оны 5 дугаар сарын 08-ны өдөр хуралдуулан “Улаанбурхан, улаануудын эсрэг вакцинаар дархлаажуулах хүүхдийн насны тов”-ыг хэлэлцүүлэн зөвлөмж гаргуулж, санал, зөвлөмжийг эрүүл мэндийн яаманд албан бичгээр хүргүүлсэн.<br>- ЭМС-ын 2023.05.22-ны өдрийн А/180 дугаар “Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх тухай”<br>- ЭМС-ын 2023.05.26-ны өдрийн А/188 дугаар “Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг вакцинаар нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах” тушаалын төслийг боловсруулж батлуулсан.<br>- “Улаанбурхан өвчнөөс хамтдаа сэргийлье” уриан дор зохион байгуулагдах нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зориулсан гарын авлага боловсруулж, хүргүүлсэн.<br>- “Улаанбурхан өвчнөөс хамтдаа сэргийлье нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах” арга зүйн сургалтыг 2023.05.26-ны өдөр аймаг, дүүрэг, өрх, сумын эрүүл мэндийн төвийн 1000 гаруй эмч, мэргэжилтнүүдийг хамруулан цахим сургалтыг хийсэн.<br>- Нэмэлт дархлаажуулалтад хэрэглэх УУ вакциныг эхний 350 000 хүн тунг 2023.05.29-ны өдөр, дараагийн 300 000 тунг 6 сарын 1-ны өдөр хүлээн авч 21 аймаг, 9 дүүрэгт тарааж түгээсэн.<br>- Иргэдэд УУ нэмэлт дархлаажуулалтын талаар мэдээлэл хүргэх 2 ТВ шторк, анонс, постер бэлтгэн үндэсний ТВ, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болон 21 аймаг 9 дүүрэгт хүргүүлсэн.<br>- 9-р сард нэмэлт дархлаажуулалтыг дахин эхлүүлэх ЭМС-ын албан даалгаварыг 21 аймаг, 9 дүүрэгт хүргүүлсэн энэ хүрээнд цахим сургалтыг зохион байгуулсан.<br><br>ЭМС-ын 2023 оны 5 сарын 26-ны өдрийн "Улаанбурхан, улаанууд өвчний эсрэг вакцинаар нэмэлт дархлаажуулалт зохион байгуулах тухай" А/188 тоот тушаалын дагуу 2023 оны 5 сарын 29-ны өдрөөс эхлэн улсын хэмжээнд нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулж байна. 2023 оны 11 сарын 10-ны байдлаар улсын хэмжээнд зорилтот бүлгийн 309,310 (48%) хүүхэд хамрагдсан байна. Үүнээс Нийслэлд 115,289 (38%), аймагт 194,021 (58%) хүүхэд тус тус хамрагдаад байна. Улсын хэмжээнд улаанбурхан, улаануудын эсрэг вакцинд хамрагдаад байгаа хүүхдүүдийн 21% (n=63,975)-д нь явуулын дархлаажуулалтын үйлчилгээг үзүүлсэн байна.<br><br>Товлолын дархлаажуулалтын УГУ 1 дүгээр тун 94,7%, 2 дугаар тун 94,1% хамралттай байна.<br><br>"Халдварт саа өвчнийг устгасан байдал"-аа хадгалах хүрээнд товлолын дархлаажуулалтын Халдварт саагийн вакцины хамралт 2023 оны эхний 9 сарын бадлаар 0 тун-99,6%, 1-р тун 97,5%, 2-р тун 96,4%, 3-р тун 96,1%, 4-р тун 95,7% байна<br><br>Товлолт дархлаажуулалтаас хоцорсон хүүхдийг хамруулах нөхөн дархлаажуулалтыг сар бүр зохион байгуулж байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | – НЭМҮТ-ийн полиогийн багтай санал солилцох уулзалт, ярилцлагыг зохион байгуулж цаашид хийх ажлын санал солилцсон. | | |
| **2.17** | 2023-2024 онд зорилтот бүлгийн хүн амыг томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулна. | 5.5 тэр бум (Улсын төсөв) | Томуугийн вакцинжуулалтын хамралтын хувь, хамрагдсан хүний тоо, тайлан | Жил бүр улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулдаг ба 2022 онд зорилтот бүлгийн хүн амын 40 хувийг вакцинжуулсан | Манай улс 2022/2023 оны томуугийн улирлыг угтуулж, Засгийн газраас 500.000 тун БНСУ-д үйлдвэрлэгдсэн GCFlu 4 цэнт вакциныг, Даян дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 45.000 тун БНСУ-д үйлдвэрлэгдсэн GCFlu 3 цэнт вакциныг хүлээн авч эрүүл мэндийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/512 дугаар тушаалын дагуу улсын хэмжээнд 1-12 хүртэлх насны хүүхдүүд, эмч, эмнэлгийн ажилчид, 65 ба түүнээс дээш насны ахмадууд, архаг суурь өвчтэй иргэдийг вакцинжуулж байна. 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд улирлын томуугийн эсрэг вакцины хамралт 86.2% (469,857), орон нутагт 91.8% (240,093), нийслэлд 81,1% (229,764)-тай байна.<br>2023-2024 онд улирлын томуугийн эсрэг вакцинаар зорилтот бүлгийн хүн амыг дархлаажуулахад шаардлагатай 300,000 хүн тун 4 цэнт вакциныг НҮБ-ын Хүүхдийн санд захиалж, Засгийн газар, Эрүүл мэндийн яамнаас төлбөрийг хугацаанд шилжүүлж, хүлээн авсан. Мөн 2023/2024 оны томуугийн улирлыг угтуулж 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс улсын хэмжээнд улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах ажлыг зохион байгуулж байна.<br>– 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар вакцины хамралтын мэдээг 30 (21 аймаг, 9 дүүрэг) байгууллагаас ирүүлсэн ба хамралтын хувь 88.7% (266,164)-тай байна. Орон нутагт 93.7% (135,699), нийслэлд 84.1% (130,465)-тай байна. | 100% | Зорилтот хүн амын 50 хувийг вакцинжуулж томуугийн өвчлөл, хүндрэлээс сэргийлсэн байна. |

| ЗОРИЛТ 3. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД УДИРДАМЖ, ЗААВРЫГ ЧАНД МӨРДӨХ, ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ТАСРАЛТГҮЙ САЙЖРУУЛАХ, ШИНЭ ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИЙГ НЭВТРҮҮЛЭХ | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **3.1** | Төвийн хэмжээнд ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлнэ. | 30 сая төгрөг (Дотоод нөөц) | ISO 9001:2015 стандартын гэрчилгээ | ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна. | ISO 9001:2015 Олон улсын стандартыг нэвтрүүлэхээр төвийн Ерөнхий захирлын 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/267 тоот тушаалын дагуу ажлын хэсэг гарган төлөвлөгөөний дагуу ажилласан. Төслийн нийт үргэлжлэх хугацааг 5 сар байхаар төлөвлөсөн ба нь 2022 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс 2023 оны 2 дугаар сарын 28-ныг хүртэл төлөвлөсөн бөгөөд хамрах хүрээг нэмсэн. “Хэвтүүлэн эмчлэх үйл ажиллагаа”-г ISO 9001:2015 стандартын шаардлагад нийцүүлэх хүсэлт гаргасны дагуу хамрах хүрээг нэмж, 2023 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл ажиллахаар төлөвлөж, 2023 оны 5 дугаар сарын 16-нд ажлын даалгаврыг бүрэн хэрэгжүүлж дуусгасан.<br>Зөвлөх үйлчилгээний хүрээнд 2022 оны 10 дугаар сарын 02-ноос 2023 оны 05 дугаар сарын 12-ны хугацаанд:<br>- ISO 9001 стандартын танилцуулга, цахим сургалт-274 эмч ажилчидад<br>- ЧМТ ба ISO 9001 шаардлага, хэрэгжүүлэх арга зүй вакум сургалт-ЧАБАлбаны дарга, ажилтнуудад<br>Зөвлөх үйлчилгээний хүрээнд 2022 оны 10 дугаар сарын 2-ноос 2023 оны 05 дугаар сарын 12-ны хугацаанд:<br>• Бэлтгэл үеийн сургалт<br>• Төлөвлөлт шийдлийн үеийн сургалт<br>Нийт 23 удаагийн сургалт хийсэн. Нийт 88 цагийн сургалтад 798 (давхардсан тоогоор) эмнэлгийн ажилтан хамрагдсан.<br>- 2023.01.05-ны өдрийн 13:00 цагаас ЧМТ -г бий болгох, хэрэгжүүлэх, шинэчлэх, тасралтгүй сайжруулахад шаардлагатай нөөцийг тодорхойлсон. Ерөнхий захирал, дэд захирал, 5 албаны дарга, чанарын менежерүүд болон 13 тасгийн эрхлэгч нар | 100% | Төвийн хэмжээнд ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлсэн байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамрагдсан.<br>- 2023.01.12-ны өдрийн 13:00 цагаас Хяналт, дүн шинжилгээ, үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлэх сургалт- 3 албаны дарга, чанарын менежерүүд болон 15 тасгийн эрхлэгч, 4 эмч, 10 ахлах сувилагч нар хамрагдсан.<br>Гадаад, дотоод асуудлыг тодорхойлсон.<br>Сонирхогч талууд, тэдний хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон.<br>Үйл явцын зураглалыг тодорхойлсон.<br>24 үйл явцын зураглал тодорхойлсон.<br>2022 оны 11 дүгээр сарын 10-наас 15-ны өдрүүдэд Цэргийн төв эмнэлэг дээр ЧМТ ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх, тогтолцооны хэрэгжилтэд явцын хяналт үнэлгээ хийх аудитын сургалтанд 5 эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.<br>ХӨСҮТ дээр онол ба дадлага хосолсон хэлбэрээр 2023 оны 04 дүгээр сарын 17-ноос 21-ний хооронд зохион байгуулсан. Дотоод аудитор бэлтгэх сургалтанд **20 эмнэлгийн ажилтан** хамрагдсан. Дотоод аудиторын онолын сургалтыг 04 дүгээр сарын 17,18-ны өдрүүдэд, дотоод аудитыг эмнэлгийн 26 нэгжид 04 дүгээр сарын 19, 20-ны өдрүүдэд хийсэн.<br>2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр эмнэлгийн удирдлагуудыг оролцуулан Удирдлагын дүн шинжилгээний хурлыг хийж, Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартын нэвтрүүлсэн үйл ажиллагааны үр дүнг хэлэлцүүлсэн.<br>2023 оны 6 дугаар сарын 30-нд ISO 9001:2016 гэрчилгээг гардан авч баталгаажуулсан. | | |
| **3.2** | “Элэг бүтэн Монгол” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | - | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | - | ХӨСҮТ-ийн хэмжээнд нийт 22632 элэгний архаг үрэвсэл болон элэгний хатуурал, элэгний цочмог үрэвсэлтэй үйлчлүүлэгчидэд тусламж, үйлчилгээ үзүүлсэн. Үүнд: | 75% | Арга хэмжээний хэрэгжилт 30 хувьд хүрсэн байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - В,Д вирусын хавсарсан халдвартай 4140<br>- Архаг С вируст хепатит 4990<br>- Архаг В вируст хепатит 3023<br>- Шалтгаан тодоройгүй элэгний архаг үрэвсэл 3178<br>- Элэгний хатуурал 1713 үйлчлүүлэгч байна.<br>- Цочмог В вируст хепатит 94<br>- Цочмог С вируст хепатит 133<br>- Цочмог А вируст хепатит 7<br>- Цочмог В, Д вирус хавсарсан хепатит 45<br>- Сайн дурын дархлаажуулалатаар В вирусын вакциныг 5019 хүн тунг үйлчлүүлэгч нарт хийсэн.<br><br>2019 оноос Ковид-19 халдварын дэгдэлттэй холбоотойгоор ХӨСҮТ-ийн Амбулаторийн тасаг бүрэн хаагдаж элэгний В,С, Д вируст халдвартай цочмог, архаг үрэвсэлтэй үйлчлүүлэгч нарт үзүүлэх тусламж үйлчилгээ түр хугацаагаар зогсож, амбулаторийн эмч нар ковидын тасагт дайчлагдан ажилласан. Үүнтэй холбоотойгоор гадаад болон дотоод сургалт, семинар зогссон.<br><br>2023 онд орон даяар урьдчилсан сэргийлэх эрт илрүүлэгтэй холбоотойгоор С вируст халдвартай үйлчлүүлэгчийн тоо ихэссэн. С вирусын эмчилгээнд хэрэглэгдэж буй Лидвер эм тасарсан тул үйлчлүүлэгчид эмээ ууж чадахгүй ужгирч архагших хандлагатай байна.Үйлчлүүлэгчийн 70-80 хувь нь 1-2 хайрцаг эм уугаад тасарч өвчний тавиланд муугаар нөлөөлж байна. /Эмийн дасал үүсэх эрсдэлтэй/. В вирусын халдвартай элэгний архаг үрэвсэлтэй хатууралтай жирэмсэн эхчүүдэд, В | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | вирусын идэвхжил өндөртэй эхчүүд B вирусын эм тенофовир 300 мг ууж чадахгүй байгаа нь жирэмсэн эхээс вирусын халдвартай хүүхэд төрөх магадлал өндөр болж байна. /Эм тасарсантай холбоотой/ | | |
| **3.3** | Зонхилон тохиолдох халдварт өвчний эмнэлзүйн удирдамж, зааврыг шинэчлэн батлуулж, мөрдөнө. | 30 сая төгрөг (Улсын төсөв) | Шинэчлэн батлагдсан эмнэлзүйн удирдамж, заавар | 2016 оны халдварт өвчний тандалт, судалгаа, оношилгоо, эмчилгээний стандартыг мөрдөн ажилладаг. | Зонхилон тохиолдох 56 халдварт өвчний эмнэлзүйн заавар боловсруулсан.<br><br>Халдварт өвчний үед ашиглагдаж буй 2016 оны стандартыг шинэчлэн ЭМС-ын 2017 оны А/477 дугаар тушаалын дагуу Халдварт өвчний эмнэлзүйн заавар нэртэйгээр шинэчлэн боловсруулж, халдварт өвчний мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүдээр хянуулсан. ЭМЯ-ны тушаал болгон батлуулах ажил үргэлжилж байна. ХӨСҮТ-ийн ерөнхий захирлын 2022 оны 6 дугаар сарын 21-ны өдрийн “Эмнэлзүйн зааврыг шинэчлэн боловсруулах тухай” А/138 дугаар тушаалаар шинэчлэн боловсруулах эмнэлзүйн зааврууд болон заавар боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Шинэчлэн боловруулсан эмнэлзүйн зааврuудыг хөдөө орон нутаг, Улаанбаатар хотын дүүргүүд, ХӨСҮТ-ийн халдвартын эмч, резиденс эмч, 100 эмчид 2 өдрийн сургалтыг зохион байгуулсан. | 100% | Халдварт өвчний эмнэлзүйн шинэчлэгдсэн удирдамж, зааврыг мөрдөн ажилласан байна. |
| **3.4** | Сүрьеэ өвчний эмнэлзүйн удирдамж, зааврыг шинэчлэн батлуулж, мөрдөнө. | 30 сая төгрөг (Улсын төсөв) | Шинэчлэн батлагдсан эмнэлзүйн удирдамж, заавар | 2021 оны сүрьеэгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам, зааврыг мөрдөн ажилладаг. | 2022 оны 11 дүгээр сарын 29-ний А/286 дугаар тушаалаар Эрүүл мэндийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн Сүрьеэ өвчний эмнэлзүйн удирдамж, заавар батлах тухай А/30 дугаар тушаал шинэчлэгдэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Одоогийн байдлаар удирдамж боловсруулалт хэвлэгдэх шатандаа явагдаж байна. | 98% | Сүрьеэ өвчний эмнэлзүйн шинэчлэгдсэн удирдамж, зааврыг мөрдөн ажилласан байна. |
| **3.5** | Заавал мэдээлэх халдварт өвчний жагсаалтыг тэргүүлэх эрэмбээр шинэчлэн тогтоож, журам, | 51 сая төгрөг (Дотоод нөөц) | Батлагдсан журам, заавар | 2017 онд тэргүүлэх эрэмбийг тогтоож, журам, заавар | Халдварт өвчний тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тогтоох ДЭМБ-аас гаргасан аргачлал, удирдамжийг орчуулан бэлтгэл ажлыг хангасан. Үнэлгээ хийх шалгуурыг | 50% | Шинэчлэгдсэн журам, зааврыг мөрдөн ажилласан |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зааврыг боловсруулан батлуулж, мөрдөнө. | | | батлуулсан. | гаргасан.<br><br>Тэргүүлэх чиглэл тогтоох үйл ажиллагаанд шаардлагатай 70,0 сая төгрөгний санхүүжилтийн хүсэлт, удирдамжийг төвийн ерөнхий захирлаар батлуулан ДЭМБ-ын Суурин төлөөлөгчийн газарт 2023 оны 4 дүгээр сард хүргүүлсэн боловч хариу өгөөгүй, санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй. | | байна. |
| **3.6** | Томуугийн цар тахлын бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэн боловсруулан батлуулж, мөрдөнө. | 30 сая төгрөг (ДЭМБ) | Хэрэгжилтийн хувь | Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/438 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад заагдсан төлөвлөгөөний хугацаа дууссан. | Улаанбаатар хот болон Дорноговь, Дорнод, Өмнөговь, Сэлэнгэ зэрэг аймгуудад “Томуугийн болзошгүй цар тахлын бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулах 1 өдрийн сургалт, 2 өдрийн ширээний дасгал сургуулилт, хэлэлцүүлгийг ЭМЯ, УОК, ОБЕГ, ХӨСҮТ, БСШУЯ, ГЕГ, ЗӨСҮТ, НЭМГ, ЭХЭМҮТ, НЭМҮТ, УНТЭ, МЭХ, УМЭАЦТЛ зэрэг олон салбарын 200 орчим мэргэжилтнүүдийг хамруулан, амжилттай зохион байгуулсан. ДЭМБ-ын дэмжлэгтэй хийгдэж буй энэхүү үйл ажиллагааны хүрээнд ДЭМБ-аас 2 зөвлөх мэргэжилтэн 2023 оны 4 дүгээр сарын 17-оос 22-ны өдрүүдэд ажиллаж, сургалт болон ширээний дасгал сургуулилт хийсэн.<br><br>ДЭМБ-ын гарын авлага, ЭМС-ын коронавируст халдвар (КОВИД-19) болон томуу, томуу төст өвчний тандалтын тушаал, бусад улс орны томуугийн цартахлын бэлэн байдал, хариу арга хэмжээний төвлөвлөгөөг үндэслэл болгон томуугийн цартахлын бэлэн байдал хариу арга хэмжээний удирдамжийн төслийг шинэчлэн боловсруулсан.<br><br>Цаашид салбар хоорондын байгууллагын удирдлагуудад танилцуулан санал зөвлөмж авах уулзалт, хэлэлцүүлгийг | 100% | Төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, мөрдөн ажилласан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулахаар төлөвлөж байна. | | |
| **3.7** | Хүүхдийн байгууллагад чиглэсэн халдварт өвчнийг тандах тандалтын заавры боловсруулан батлуулж, мөрдөнө. | 22 сая төгрөг (ДЭМБ) | Батлагдсан заавар | - | КОВИД-19-ын тандалт, хариу арга хэмжээний заавaрт хүүхдийн байгууллага, цэргийн анги, асрамжийн газар зэрэг хаалттай орчинд тандалт хийх удирдамж тусгасан.<br><br>Хүүхдийн байгууллагад дэгдэлт хэлбэрээр бүртгэгддэг цочмог халдварын тандалтын заавар, журмыг боловсруулж, ЭМС, БШУС-ын хамтарсан тушаал байдлаар гаргуулахаар мэргэжилтнүүдээс санал авах түвшинд явж байна.<br>Энэхүү журмын зорилго нь сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн орчинд цочмог халдварт өвчнийг эрт илрүүлэх, халдвараас сэргийлэх бэлэн байдлыг хангах, халдвар бүртгэгдсэн тохиолдолд хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах юм.<br><br>Журам нь 3 хавсралт бүхий хэсгээс бүрдэнэ. | 70% | Батлагдсан заавры мөрдөн ажилласан байна. |
| **3.8** | Эмэнд тэсвэртэй бичил биетнийг тандах тандалтын заавры боловсруулан батлуулж, мөрдөнө. | 40 сая төгрөг (Төсөл, хөтөлбөрийн хүрээнд) | Батлагдсан заавар | - | Сонгогдсон 15 эмнэлгийн халдварын сэргийлэлт хяналт, эмчилгээ тусламж үйлчилгээний чанар, сувилахуйн алба, нян судлалын лаборатори болон эрчимт эмчилгээ, мэс засал, эх барих эмч, сувилагч зэрэг багаар нь эмнэлэг тус бүрээс 15 ажилтанг нийт 238 ажилтныг хамруулан ЭТҮХХ-ыг илрүүлэх идэвхтэй тандалтын аргачлал, халдварыг бүртгэж, мэдээлэх, тохиолдлын судалгаа, нян судлалын лабораторийн шалгуур үзүүлэлт, шинжилгээний хариуг дүгнэх, бичил биетний тэсвэржилтийн тандалт, сэргийлэлтийн чиглэлээр ажлын байран дахь сургалтыг хийсэн.<br><br>ХӨСҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны | 50% | Батлагдсан заавры мөрдөн ажилласан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 09 дүгээр сарын 21-ны өдрийн А/155 дугаар тушаалаар Эмэнд тэсвэртэй бичил биетнийг тандах тандалтын заавар боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. | | |
| **3.9** | Зонхилон тохиолдох гэдэсний халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх талаар гарсан тушаалын хэрэгжилтэд үнэлгээ хийж, шинэчлэн батлуулж, мөрдөнө. | 33 сая төгрөг (ДЭМБ) | Шинэчлэн батлагдсан тушаал | - | ХӨСҮТ-ийн Ерөнхий захирлын тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан.<br>Одоо мөрдөгдөж буй тушаал зааврын хэрэгжилтэд үнэлгээ хийгдсэн.<br>Тушаалыг шинэчлэн боловсруулахаар ажиллаж байна. ДЭМБ-д тухайн үйл ажилллагаатай холбоотой гарах төсөвт санхүүжилт олгох хүсэлт, удирдамжийг Ерөнхий захирлаар батлуулж хүргүүлсэн.<br><br>Энэ онд санхүүжилт олдоогүй тул үйл ажиллагаа бүрэн хэрэгжээгүй байна. | 50% | Батлагдсан тушаалыг мөрдөн ажилласан байна. |
| **3.10** | Тус төвд ашиглах антибиотик эмчилгээний удирдамж, гарын авлагыг гаргаж мөрдөнө. | Дотоод нөөц | ХӨСҮТ-ийн антибиотик эмчилгээний гарын авлага | - | Тус төвийн эмчилгээний тасагт *Clostridioides difficile*- ийн халдвар бүртгэгдсэнтэй холбоотой тус үүсгэгчийн талаархи CDC-ийн удирдамж, зааврыг орчуулж ХСХ-ын алба/багт хүргүүлж, эмнэлзүйн тасгийн эмч, мэргэжилтнүүдэд түгээсэн.<br>Тус төвийн халдварын сэргийлэлт, хяналтын алба, чанарын алба, сувилахуйн алба, мэс засал, сэхээн амьдруулах, нян судлалын лаборатори зэргийн эмч мэргэжилтэнг оролцуулсан 15 ажилтанд “Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын тандалт, лабораторийн оролцоо” сэдэвт онол, дадлага хосолсон 2 өдрийн ажлын байран дахь сургалтыг зохион байгуулсан.<br>Антибиотик эмчилгээний удирдамж, гарын авлагын боловсруулалт хийгдэж байна. | 50% | Антибиотик эмчилгээний удирдамж, гарын авлагыг хэвлүүлж, бүх эмч нарт түгээсэн байна. |
| **3.11** | Үндэсний хэмжээнд халдварт өвчний Иммунологи, Нян | 100 сая төгрөг (Дотоод нөөц) | Чанарын гадаад хяналтын | 125 лаборатори хамрагдсан. | – Чанарын баталгаажуулалтын лаборатори байгуулж, Лавлах шинжилгээг хийх, лабораториудад | 100% | Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | судлал, Вирус судлал, Сүрьеэгийн оношлогооны чиглэлээр чанарын гадаад үнэлгээг зохион байгуулна. | | гэрчилгээ | | чанарын хяналт хийх үйл ажиллагааг эхлүүлэх тухай Эрүүл мэндийн сайдын 2007 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 299 дүгээр тушаалд заасны дагуу Халдварт өвчин судлалын үндэсний төв нь Улсын хэмжээнд иммунологийн шинжилгээний чиглэлээр 2012 оноос үндэсний хэмжээнд чанарын гадаад үнэлгээг явуулсаар байна.<br>– 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Үндэсний чанарын гадаад үнэлгээг ХДХВ/ДОХ, Тэмбүү, хепатитын В, С халдвар илрүүлэх шинжилгээ хийж буй II, III шатлал, 21 аймаг, 9 дүүрэг, клиникийн төв эмнэлгүүд, 1, 2, 3 дугаар амаржих газар, хувийн хэвшлийн лабораториудыг хамруулан явуулж байгаа бөгөөд 11 дэх жилдээ нийт 19 удаагийн үнэлгээг явуулаад байна. Анх 30 лаборатори хамрагдаж байсан бол 2023 онд 135 лабораторийг хамруулж, хяналтын багцын сорьцыг бэлтгэн оролцогч нарт тарааж хариуг хүлээн авч байна.<br>– 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Үндэсний чанарын гадаад үнэлгээний хөтөлбөрийн 20 дахь ээлжийг зохион байгуулж байгаа ба ХДХВ/ДОХ, Тэмбүү, хепатитын В, С, Д халдвар илрүүлэх, хепатит В, С нуклейн хүчлийн ачаалал тодорхойлох, Нян судлалын ялган дүйлт, антибиотик мэдрэг тодорхойлох, Сүрьеэгийн түрхэцийн шинжилгээгээр тус тус хамруулан илгээлээ. | | явуулж буй лабораторийн 50-аас дээш хувийг үнэлгээнд хамруулсан байна. |
| **3.12** | Олон улсын болон ДЭМБ-ын бүсийн лавлагаа лабораториудаас явуулж буй чанарын гадаад хяналт, ур | 50 сая төгрөг (Дотоод нөөц) | Чанарын гадаад хяналтад хамрагдсан байдал | 2022 онд Австрали улсын NRL болон бусад Олон улсын чанарын | – Австрали Улсын Үндэсний Лавлагаа лабораторитэй 2011 онд хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд БЗДХ болох тэмбүү, ХДХВ илрүүлэх ийлдэс судлал, ХДХВ, БЗДХ-ын молекул биологийн шинжилгээгээр | 100%<br>(2023 оны 11, 12 сард ирж байгаа 4- | Чанарын гадаад хяналтад хамрагдан гэрчилгээ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | чадварын сорилтонд хамрагдаж, үр дүнд дүгнэлт хийн ажиллана. | | | хяналтад хамрагдсан. | 2023 онд гадаад чанарын хяналтанд орохоор материалаа өгсөн. Хуваарийн дагуу жилд 2 удаа, 5, 11 дүгээр саруудад хамрагдна.<br>– Эрүүл мэндийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/528 дугаар тушаалын “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөний” Зорилт 6: (6.2.1) Халдварт өвчнийг илрүүлэх, тандах, оношлох лабораторийн гадаад чанарын хүрээг өргөжүүлэх, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 6/1138 дугаар тушаалын “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог үндэсний түвшинд шинэчлэн, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлэх” ажлын төлөвлөгөөнд олон улсын байгууллагын дэмжлэгтэй хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд шинээр заг хүйтэн, папиллома вирус илрүүлэх молекул биологийн гадаад чанарын хяналтанд хамрагдах хүсэлт удирдамжийг ДЭМБ-д хүргүүлсэн.<br>– 2023 оны 5 сард Австрали улсын VIDRL-лабораторийн улаанбурхан ба улаануудын гадаад хяналтын 40 сорьц хүлээн авч шинжилгээ хийж хариуг илгээн 100% үнэлгээ авсан.<br>– 2023 оны 10сард Хонг-Конгийн лавалгаа лабораторид улаанбурхан-30, улаануудын-30 сорьц илгээж 100% гэсэн үнэлгээ авсан.<br>– 2023 оны 11 сард иммунологи, молекул биологийн Австралийн чанарын хяналт ирж шинижлгээг хийн хариуг илгээсэн, Үнэлгээ 2024 онд ирнэ. | р улирлын хяналт үнэлгээний дүн 2024 оны эхэнд гарна). | авсан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | – Гепатит Энтеровирусийн лаборатори нь Австрали улсын Ийлдэс судлалын лавлагаа лабораториос зохион байгуулдаг Олон улсын чанарын гадаад хяналтанд ГВВ, ГСВ-н илрүүлэг шинжилгээгээр 2 удаа, ГВВ, ГСВ-н ачаалал тоолох шинжилгээгээр 1 удаа хамрагдаж 100% үнэлгээ авсан. Гепатит Д вирусийн ачаалал тоолох шинжилгээгээр ИБУИНВУ-н QCMD олон улсын чанарын гадаад хяналтанд оролцож, хариуг 2023 оны 11-р сарын 17-нд илгээсэн. Хяналтын тайлан ирээгүй байна.<br>– ДЭМБ-ын бүсийн СХХА-ийн ББТ-ээр Гадаад чанарын хяналтанд Нян судлалын лаборатори хамрагдахаар зорилгоор 5 мэргэжилтэн сургалтанд хамрагдаж, бэлтгэл ажил дуусч, шалгуур тест хүлээн авах гэж байна.<br>– КХЛ нь Австралийн RCPAQAP чанарын гадаад хяналтанд биохими, гематологи, бүлэгнэлт, шээсний шинжилгээгээр сар, улирал, хагас жил гэсэн давтамжтайгаар хамрагдан ажиллаж байна. Одоогийн байдлаар 2023 оны үр дүн 100% оролцож байна.Энэ оны зарим хяналтууд хийгдэх хугацаа болоогүй байгаа болно<br>– ДЭМБ-ын харъяа ОХУ -ын Эрхүү хотын Хүний нөхөн үржхүйн эрдэм шинжилгээн төвд хатран ажилах гэрэээний 2-3 т заасаны дагуу жилд нэг удаа чанарын гадаад хяналтанд орохоор болсон | | |
| **3.13** | Түрхцийн шинжилгээний гадаад чанарын хяналтыг хийнэ. | 14.1 сая төгрөг (Дотоод нөөц) | Хамрагдсан нэгжийн тоо | Жил бүр хийгддэг. | Жилд 1 удаа зохион байгуулдаг түрхцийн шинжилгээний 2023 оны чанарын гадаад үнэлгээг 2023 оны 11 дүгээр сарын 29-д тараахаар бэлтгэл ажил хийгдэж байна. 2022 оны 4 дүгээр улирлын чанарын | 100% | Нийт 36 нэгжийг хамруулсан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хяналт 2023 оны 1 дүгээр улиралд буюу 1 улирлаар ухарч хийгддэг. 35 лаборатори хамрагдаж, хамрагдалт 89.3%, 34 лаборатори хангалттай гүйцэтгэлтэй үнэлэгдэж, 1 лаборатори хангалтгүй гүйцэтгэлтэй байна. Улсын гүйцэтгэлээр 97.1% байна. 2023 оны 1 дүгээр улиралд 36 лаборатори хамрагдаж бүгд хангалттай гүйцэтгэлтэй оролцсон. 2023 оны 2-р улиралд 34 лаборатори хамрагдаж Хамрагдалт 81.2%, 33 лаборатори хангалттай гүйцэтгэлтэй үнэлэгдэж, 1 лаборатори хангалтгүй гүйцэтгэлтэй оролцсон байна. Улсын гүйцэтгэлээр 97.1% байна. 3-р улирлын чанарын хяналтын түрхэц шалгагдаж байна. | | |
| **3.14** | Xpert MTB/RIF шинжилгээнд чанарын гадаад үнэлгээ (SmartSpot Quality's Xpert EQA Program 2 panel/year)-г хийнэ. | 44.6 сая төгрөг (Глобаль сан) | Хамрагдсан нэгжийн тоо | 2022 онд 2 удаа чанарын гадаад үнэлгээ хийсэн. | Чанарын гадаад үнэлгээний эхний шатанд нийт 41 лабораторийн 41 төхөөрөмж хамрагдсан. 40 лабораторийн 40 төхөөрөмж (97,56%) дээр хийгдсэн хяналт 100% буюу хангалттай, 1 лаборатори 75% буюу асуудалтай түвшинд байна гэж үнэлэгдсэн ба хангалтгүй үнэлэгдсэн лаборатори байсангүй. 2 дахь удаагийн чанарын хяналтын материалыг төлөвлөгөөний дагуу 11 дүгээр сард тараасан бөгөөд бүх лабораториудад үнэлгээнд хамрагдаж, үр дүнг нэгтгэж байна. | 100% | Нийт 41 нэгж лабораторийг 2 удаа үнэлгээнд хамруулсан байна. |
| **3.15** | Өндөр даралтат хүчилтөрөгчийн эмчилгээ (барокамер)-г нэвтрүүлнэ. | Дотоод нөөц | Эмчилгээ хийлгэсэн хүний тоо | Барокамерийг суурилуулсан. | Өндөр даралтат хүчилтөрөгчийн эмчилгээ (барокамер)-г 2022 оны IV улиралд бүрэн ашиглалтанд оруулж, ЭТТ-ийн инженер 1, техникч 1 сурган бүрэн ажиллагаанд оруулсан бөгөөд одоогийн байдлаар томуугийн өвчлөл нэмэгдэж төвийн орны тоо ЭМЯ-ны мэдээгээр 163, бодит байдал дээр 223 хүрсэн тул түр хугацаагаар хэвтэн эмчлүүлэгчийн өрөөг ашиглах үүднээс зогсоосон байна. | 100% | Өндөр даралтат хүчилтөрөгчийн эмчилгээ (барокамер)-г нэвтрүүлсэн байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **3.16** | Хепатит Д вирусын нуклейн хүчлийн хэмжээг тодорхойлох бх-ПГУ шинжилгээний аргыг нэвтрүүлнэ. | 60 сая төгрөг (Дотоод нөөц) | Шинжилгээний тоо | ОУ-ын чанарын гадаад хяналтад хамрагдаж, ЭМДЕГ-т хүсэлт гаргасан. | Хепатит Энтеровирусийн лаборатори нь 2021 оноос Хепатит Д вирусийн нуклейн хүчлийн хэмжээг бодит хугацааны полимеразийн гинжин урвалын аргаар тодорхойлох шинжилгээг хийхээр шинжилгээний протокол, САЗ-ыг боловсруулсан. Туршилтын шинжилгээнүүд болон аргын баталгаажуулалт, лаборатори хоорондын харьцуулалтын шинжилгээнүүд хийгдсэн. 2021 онд ИБУИНВУ-н QCMD Олон Улсын чанарын хяналтанд хамрагдан, 100%-ийн гүйцэтгэлтэй сертификат авсан. Тус төвийн Ерөнхий захирлын төлбөртэй тусламж, үйлчилгээний журамд HDVRNA шинжилгээний төлбөрийг оруулах шаардлагатай байгаа ба HDVRNA тодорхойлох шинжилгээг үйлчлүүлэгчдэд хийхэд бэлэн болсон.<br><br>Гепатит Д вирусийн ачаалал тоолох шинжилгээг 2023 оны 11-р сараас эхлэн ЭМД-н санхүүжилтээр тоолж эхэлсэн ба энэ хугацаанд нийт 108 хүнд Д вирусийн ачаалал тоолох шинжилгээг ЭМД-ын санхүүжилтээр хийсэн байна. | 100% | Шинэ аргыг нэвтрүүлж, шинжилгээ хийсэн байна. |
| **3.17** | Шимэгч хорхой болон гэдэсний шимэгчийн халдварыг илрүүлэх Allplex GI-Parasite Assay болон Allplex GI-Helminth Assay цомгийг ашиглан молекул биологийн аргаар илрүүлэг шинжилгээ хийнэ. | 105 сая төгрөг (Дотоод нөөц) | Шинжилгээний тоо | - | Шимэгч хорхой болон гэдэсний шимэгчийн халдвар, хачгаар дамжих шимэгчийн халдварыг илрүүлэх ПСР шинжилгээний оношлуурыг 2023 оны тендерийн захиалгад оруулан захиалсан бөгөөд одоогоор нийлүүлэлт хийгдэж эхлээгүй байна. Шинжилгээнд хэрэглэгдэх багаж тоног төхөөрөмжүүд болон өрөө тасалгааг бэлтгэн тохижуулж байна. Үүнтэй холбогдуулан бэлтгэл ажил болон зарлан мэдээлийн ажлууд хийгдэж байна. | 50% | Эмч мэргэжилтнүүдийг сургаж, молекул биологийн аргаар илрүүлэг шинжилгээ хийсэн байна. |
| **ЗОРИЛТ 4. СУРГАЛТ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ТҮВШИНГ ОЛОН УЛСЫН ЖИШИГТ ХҮРГЭХ, ДЭМЖЛЭГТ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ, ГАДААД ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **4.1** | Халдвартын болон сүрьеэ судлалын үндсэн мэргэжил эзэмшүүлэх резидентийн сургалтыг зохион байгуулна. | 7.5 сая төгрөг (Дотоод нөөц) | Төгссөн резидентийн хувь | -Халдвартын резидент 12<br>-Сүрьеэгийн резидент 19 тус тус төгссөн. | - Халдвартын эмчийн үндсэн мэргэжил эзэмшүүлэх 2 жилийн сургалтыг 16 эмч суралцаж амжилттай төгсөв.<br>- Сүрьеэгийн эмчийн үндсэн мэргэжил эзэмшүүлэх 1 жилийн сургалтыг 14 эмч суралцаж амжилттай төгсөв. | 100% | - Халдвартын резидент 14<br>- Сүрьеэгийн резидент 21 тус тус төгссөн байна. |
| **4.2** | Талбарын тархвар судлалын төрөлжсөн мэргэжлийн сургалтыг зохион байгуулна. | 11.3 сая төгрөг (Дотоод нөөц) | Төгссөн мэргэжилтний хувь | Нийт 87 талбарын тархвар судлаач төгссөн. | Талбарын тархвар судлалын төрөлжсөн мэргэшлийн 2022-2023 оны элсэлтийг Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/533, нэмэлт элсэлтийг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/27 тоот тушаалын дагуу нийт 11 талбарын тархвар судлаач бэлтгэсэн. Сургалтын цөм хөтөлбөрийн дагуу онолын болон дадлагын хичээлд хамрагдаж халдварт, халдварт бус өвчин, мал эмнэлэг, зоонозын өвчин судлалын чиглэлээр нийт 21 судалгааны ажлыг гүйцэтгэж явцын болон төгсөлтийн онолын шалгалтыг зохион байгуулж үр дүнг Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлсэн. Эдгээр 11 мэргэжилтэнд 2023 оны 11 сарын 8-ны Эрүүл мэндийн сайдын А/394 тоот тушаалаар төрөлжсөн мэргэшлийн үнэмлэх олгосон. Нийт 98 талбарын тархвар судлаач төгссөн байна. | 100% | Нийт 95 талбарын тархвар судлаач төгссөн байна. |
| **4.3** | БЗДХ, ХДХВ, ДОХ судлал төрөлжсөн мэргэшил дээшлүүлэх сургалт явуулна. | 3.8 сая төгрөг (Дотоод нөөц) | Төгссөн эмчийн тоо | 2022 онд төгссөн эмч байхгүй. | 2023 оны 04 дүгээр сард БЗДХ, ХДХВ, ДОХ судлал төрөлжсөн мэргэшил дээшлүүлэх сургалтыг 11 эмч амжилттай төгссөн. | 100% | БЗДХ, ХДХВ, ДОХ судлал төрөлжсөн мэргэшил эзэмшүүлэх сургалтаар 12 эмчийг сургасан байна. |
| **4.4** | Халдварт, дархлаажуулалтын сувилагч, ариутгагчийн мэргэшил эзэмшүүлэх сургалт зохион | 22 сая төгрөг (Дотоод нөөц) | Холбогдох шалгуур хангасан суралцагчийн тоо | Мэргэшил эзэмшүүлэх сургалтаар халдвартын сувилагчийн 33, дархлаажуулал | – 2023 оны 01 дүгээр сард дархлаажуулалтын сувилахуй мэргэшүүлэх сургалтын 2022 оны намрын элсэлтийн төгсөлтийн шалгалтыг авсан. Нийт 80 вакцинатор сувилагч амжилттай төгссөн байна. | 100% | Мэргэшил эзэмшүүлэх сургалтаар халдвартын сувилагч 27, дархлаажуул |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулна. | | | тын сувилагч 99, ариутгагч 60 тус тус төгссөн. | – НҮБ-ын Хүүхдийн санд вакцинатор сувилагч сургах сургалтын хүсэлтийг хүргүүлсэн үүний дагуу 150 вакцинатор сувилагчийн мэргэшүүлэх сургалтанд хамрагдах сургалтын төлбөрийг олгож дэмжсэн.<br>– Дархлаажуулалтын сувилахуйн мэргэшил эзэмшүүлэх 2023 оны хаврын элсэлтийн сургалтыг зохион байгуулж байна. Сургалтад 18 аймаг, дүүрэг, 2 амаржих газраас нийт 60 сувилагч элсэн орж, хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулж байна.<br>– Намрын элсэлтээр 74 сувилагч элсэн суралцаж байгаа бөгөөд танхимын сургалтыг дуусгаж, дадлагад хамрагдан мэргэжил эзэмшиж байна.<br>– Энэ жилийн хувьд тус албанаас иж бүрэн сургалтын танхимыг тохижуулан ашиглаж байна.<br>– 2023 оны эхний 6 сарын байдлаар ариутгалын ажилтан бэлтгэх 3 сарын мэргэжил олгох сургалтад 41 ажилтанг хамруулж 1 сарын хугацаатай онолын сургалтыг зохион байгуулсан. Эрүүл мэндийн байгууллагуудад дадлага сургалтыг үргэлжлүүлэн хийж байна.<br>– Эрүүл мэндийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн Төрөлжсөн мэргэшил эзэмшүүлэх тухай А/94 дүгээр тушаалаар Ариутгал судлал төрөлжсөн мэргэшлийн сургалтаар 44, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/216 дугаар тушаалаар 43 суралцагч элсэн орж амжилттай төгссөн.<br>– Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/94 дугаар тушаалаар Халдвартын сувилахуй судлал сургалтаар 4 сувилагч, Эрүүл мэндийн сайдын 2023 | | алтын сувилагч 100, ариутгагч 65 тус тус төгсгөсөн байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оны А/216 дугаар тушаалаар 5 сувилагч элсэн орж амжилттай төгссөн.<br><br>Дархлаажуулалтын сувилахуй судлал сургалтаар 58 сувилагч, Халдварт өвчний сувилахуй судлал сургалтаар 11 сувилагч нийт 113 сувилагч суралцаж төгссөн | | |
| **4.5** | “Зонхилон тохиолдох халдварт өвчний сувилахуйн тусламж, халдварын сэргийлэлт, хяналт” сургалтыг зохион байгуулж, гарын авлага гаргана. | 7.5 сая төгрөг ДЭМБ | Сургалтын удирдамж, хөтөлбөр, хурлын ирц, тайлан, гарын авлага | 2022 онд үндэсний сургалт зохион байгуулаагүй ба гарын авлага 2018 онд хэвлэгдэн гарсан. | 1. Тус төвийн Дархлаажуулалтын алба, Сувилахуйн алба хамтран ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр “Зонхилон тохиолдох халдварт өвчний сувилахуйн тусламж үйлчилгээ, тархвар судлалын вакцинжуулалт” сэдэвт сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр зохион байгууллаа. Уг үйл ажиллагаанд 21 аймаг, 9 дүүргийн ЭМГ-ын вакцины хүйтэн хэлхээ хариуцсан бага эмч, нэгдсэн эмнэлгийн халдварт, яаралтай тусламжийн тасаг болон ХӨСҮТ-ийн сувилагч нар нийт 181 хүн хамрагдсан<br>2. Тус төвийн Сувилахуйн алба нь ДЭМБ, санхүүгийн дэмжлэгтэйгээр “Зонхилон тохиолдох халдварт өвчний сувилахуйн тусламж үйлчилгээ, ирээдүйн чиг хандлага” сэдэвт үндэсний сургалт, зөвлөгөөнийг 2023 оны 11 дүгээр сарын 09-10 өдрүүдэд Чингис хаан зочид буудлын хурлын танхимд амжилттай зохион байгуулсан. Үндэсний сургалт, зөвлөгөөнд ЭМЯ, ДЭМБ, АШУҮИС-ийн төлөөлөл, ХӨСҮТ, 21 аймаг, 9 дүүргийн халдварт, сүрьеэгийн тасаг, нэгжид ажилладаг сувилагч, ахлах сувилагч, Сувилахуйн албадын дарга нарын төлөөлөл, Монголын Сувилагчдын Нийгэмлэг, Халдвартын сувилагчдын нийгэмлэг гэх зэрэг төрийн болон төрийн бус байгууллагын нийт 100 төлөөлөгч оролцсон байна. | 100% | Сургалтыг зохион байгуулж, нийт 300 ширхэг гарын авлага хэвлүүлэн гаргаж, сувилагч нарын хүртээл болгосон байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **4.6** | ДЭМБ-ын Номхон Далайн Баруун Бүсийн болон Томуугийн болзошгүй цар тахлын бэлэн байдал, хариу арга хэмжээний “Кристалл” ширээний дасгал, сургуулилтыг тус тус зохион байгуулна. | 93.3 сая төгрөг (Дотоод нөөц) | Сургалтын тайлан | Жил бүр зохион байгуулдаг. | Манай байгууллага ОУЭМД-ийн үндэсний зохицуулагчийн хувьд салбар хоорондын байгууллагуудыг оролцуулан жил бүрийн 12-р сард ширээний дасгал сургуулилт зохион байгуулдаг. Энэ жил кристалл ширээний дасгал сургуулилалт Австрали, Бруней, Камбожи, Хонконг, Япон, Лаос, Макао, Малайз, Шинэ зеланд, Филиппин, БНСУ, Вьетнам, БНХАУ зэрэг 15 улстай 12-р сарын 05-ны 08.00-14.00 цагт амжилттай бэлтгэл ажлыг хангаж, сайн дүнтэй зохион байгууллаа. Тус төвийн ХӨТСАлба, ТТСАлба, НЛАлба, МТАлба, Санхүүгийн алба, ХҮТ-ийн нийт удирдлага, албан хаагчид оролцлоо. Салбар дундын байгууллагаас ЭМЯ, ОБЕГ, ГЕГ, ЭЭХХЗГ, Цөмийн энергийн комиссын ажлын алба, НЭМҮТ, ХСҮТ, ДЭМБ-ын суурин төлөөлөгчийн газраас салбар дундын оролцоог хангаж амжилттай зохион байгуулав. | 100 % | Дасгал сургуулилтыг зохион байгуулж, ЭМЯ, ОБЕГ, ГЕГ, МЭЕГ, ЗӨСҮТ, НЭМҮТ, төв эмнэлгүүд, 21 аймаг, 9 дүүргийн эмнэлэг зэрэг 133 байгууллагын 250 хүнийг хамруулсан байна. |
| **4.7** | Томуугийн тандалтын “Интернэтэд суурилсан мэдээллийн систем (FIS)”-ийг өргөтгөж, шинэчилсэн гарын авлага боловсруулан, сургалтыг зохион байгуулна. | 70 сая төгрөг (Төсөл, хөтөлбөрийн хүрээнд) | Шинэчлэгдсэн цахим системийн ашиглалтын хувь | Томуугийн тандалтын “Интернэтэд суурилсан мэдээллийн систем (FIS)”-ийн ашиглалт 40 хувьтай байна. | Интернэтэд суурилсан мэдээллийн систем (FIS)”-ийг “Робот систем” ХХК-тай гэрээ хийн шинэчлэх ажлыг хийж байна.<br><br>Энэ ажлын хүрээнд томуугийн харуулдан тандалтын нэгжүүдийн эмч мэргэжилтнүүдийг сургах сургалтын удирдамжийг боловсруулан, батлуулж ДЭМБ-аас санхүүжилтийн дэмжлэг авч сургалт хийгдсэн. Томуугийн харуулдан тандалтын нэгжүүдийн эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах бүсчилсэн сургалтыг 2023 оны 10 дугаар сарын 04-нөөс 13-ны өдрүүдэд Улаанбаатар хотод Мэдээлэл технологийн үндэсний паркийн сургалтын танхимд зохион байгуулсан. Сургалтад аймгийн ЭМГ-ын НЭМ-ийн хэлтсийн дарга, тархвар судлагч, статистикч, дүн бүртгэгч, мэдээлэл технологийн ажилтан, аймгийн НЭ, БОЭТ-ийн дүн бүртгэгч, лабораторийн мэргэжилтэн, Улаанбаатар хотын ЭМГ-ын | 100% | Томуугийн тандалтын “Интернэтэд суурилсан мэдээллийн систем”-ийг бүрэн ашиглалтад оруулсан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нийтийн эрүүл мэнд, халдвар өвчний хэлтсийн мэргэжилтэн, төвийн 6 дүүргийн тархвар судлагч нийт 136 мэргэжилтэн оролцсон.<br><br>Томуугийн мэдээллийн програмын засварыг хийж байна. Програмын шинэчлэлийн талаар Өмнөговь, Баян-Өлгий, Дархан-Уул, Дорноговь аймгууд сумын эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтэн нарт сургалтыг хийсэн ба дата менежер цахимаар оролцон програмын талаар мэдээлэл хийж байна. | | |
| **4.8** | Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын тандалтын чиглэлээр харуулдан тандалтын нэгжүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулна. | 150 сая төгрөг (Төсөл, хөтөлбөрийн хүрээнд) | Сургалтын тайлан, хамрагдсан хүний тоо | 2022 онд 15 ЭМБ-ын 225 гаруй эрүүл мэндийн ажилтанд сургалт хийсэн. | ЭТҮХХ-ын тандалт илрүүлэлт, сэргийлэлтийн чиглэлээр 38 удаагийн сургалтад давхардсан тоогоор 66 ЭМБ-ын 2322 гаруй ЭМА-ыг хамруулсан байна.<br><br>“Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын тандалт, лабораторийн оролцоо” сэдэвт онол, дадлага хосолсон 2 өдрийн сургалтыг зохион байгуулж харуулдан тандалтын 6 нэгж (УНТЭ, УХТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-2, ХӨСҮТ)-ийн 100 эмч мэргэжилтнүүдийг хамруулсан.<br><br>2022-2023 онд сургалтад хамрагдсан харуулдан тандалтын 15 нэгж ЭМБ-ын ЭТҮХХ-ын идэвхитэй тандалт, илрүүлэлтийн байдалд мэргэжил арга зүйгээр хангаж сар бүр ирүүлсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж эргэн мэдээлж байна.<br><br>2023 онд ЭТҮХХ-ын тандалтын чиглэлээр 10 харуулдан тандалтын нэгжүүдийг чадавхжуулах сургалтын удирдамж, сургалтын хөтөлбөрыг боловсруулж батлуулан ЭМЯ, ДЭМБ-д хүргүүлсэн. | 100% | Төрөлжсөн мэргэжлийн 3, аймаг орон нутгийн 4, дүүргийн 3 эмнэлгийн ажилтнууд хамрагдсан байна. |
| **4.9** | Вируст гепатитын халдварын эрт | 10 сая төгрөг (ДЭМБ) | Сургалтад хамрагдсан хүний | - | Цочмог болон архаг вируст гепатитын халдварын эрт илрүүлгийн хамралт, | 100% | 21 аймаг, нийслэлийн 9 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | илрүүлэг, тандалт, эмчилгээ, хяналтыг сайжруулах цахим сургалт зохион байгуулна. | | тоо, үр дүн | | эмчилгээний хамрагдалт, тандалт, бүртгэл мэдээлэл, эргэн мэдээлэл, “Элэг Бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр 21 аймаг, 9 дүүргийн ЭМГ, БОЭТ болон НЭ-ийн дарга, эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, дотрын эмч, халдвартын эмч, халдвар судлаач, статистикч эмч, өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 133 байгууллагын 320 гаруй эмч, мэргэжилтнүүдэд цахим сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулсан.<br><br>Мөн “Гепатитын вирусийн халдварын тандалт, урьдчилан сэргийлэлт, илрүүлэг, оношилгоо, эмчилгээ, хяналт” сэдвээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх, бэхжүүлэх, эмч, мэргэжилтэнг чадавхижуулах сургалтыг 2023 оны 12 дугаар сарын 5, 6-ны өдөр 21 аймаг, 9 дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 241 эмч, мэргэжилтнүүд цахимаар оролцсон. | | дүүргийн Эрүүл мэндийн байгуулагын 200 эмч, мэргэжилтнүүдийг сургалтад хамруулсан байна. |
| **4.10** | БЗДХ, ХДХВ/ДОХ-ын үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх талаар эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулна. | 50 сая төгрөг (ДЭМБ, Глобаль сан) | Сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний хувь | Эмнэлгийн нийт 250 мэргэжилтнийг хамруулсан. | ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албанаас 2023 оны 1 дүгээр улиралд Глобаль сангийн дэмжлэгтэйгээр Улаанбаатар хот болон орон нутгийн, ХӨСҮТ-ийн БЗДХ, ХДХВ, ДОХ-ын эмч нарт “БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж, үйлчилгээний удирдамж“-ийн шинэчлэн боловсруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг танилцуулах, шинэлэг мэдлэг мэдээлэл олгох зорилготой 2 өдрийн сургалтыг нийт 60 гаруй хүнийг хамруулан зохион байгуулсан. Мөн 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр БЗДХ, ХДХВ, ДОХ-ын чиглэлээр ажиллаж буй төр, төрийн бус байгууллагын эмч, мэргэжилтнүүдэд “БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх мэдээлэл сурталчилгааг сошиал орчинд хэрхэн амжилттай хийх” талаар дижитал маркетер бэлтгэх, чадавхижуулах сургалтыг үе шаттай зохион байгуулж | 100% | Эмнэлгийн нийт 250 мэргэжилтнийг хамруулсан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгаа ба энэ удаагийн сургалтаар хэрхэн олон талт мэдээллийг агуулсан чанартай, өнгөлөг танилцуулга (PPT) бэлтгэх талаар чадавхижуулах сургалтыг 20 эмч, мэргэжилтэнг хамруулан зохион байгуулсан.<br><br>429-р хорих ангийн удирдлагууд, эмч мэргэжилтнүүд, ажилтнуудаас бүрдсэн 20 хүнд ХДХВ-ийн халдвартай хүнд хэрхэн үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээ үзүүлэх явцад ялгаварлан гадуурхалтыг гаргахгүй байх, хувь хүний нууцыг хадлагах, хамгаалах зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулсан.<br><br>ДОХ, БЗДХ-ын тандалт судалгааны алба болон Төгс бүсгүйчүүд ТББ хамтран “Эхээс хүүхдэд ХДХВ, гепатит В вирус болон тэмбүүгийн халдвар дамжихыг зогсоох” тусламж, үйлчилгээний хүрээнд Дархан Уул, Сэлэнгэ, Дорнод, Хөвсгөл аймгуудад “Үе тэнгийн сургагч" бэлтгэх сургалт хийх, Хөвсгөл аймагт хүрэхэд төвөгтэй олон нийтийг илрүүлэх ажлыг амжилттай зохион байгуулж нийт 60 орчим үе тэнгийн сургагчийг бэлтгэсэн байна. | | |
| **4.11** | Аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдэд сүрьеэ, БЗДХ, ХДХВ, ДОХ, дархлаажуулал-тын чиглэлээр ажлын байрны сургалт, дэмжлэгт хяналтыг зохион байгуулна. | 550 сая төгрөг (Олон улсын байгууллага) | Дэмжлэгт хяналтад хамрагдсан нэгж, хүний тоо | Жил бүр дэмжлэгт хяналтыг хийдэг. | ДОХ, БЗДХ-ын тандалт судалгааны албанаас 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийг хүртлэх хугацаанд Глобаль сангийн дэмжлэгтэйгээр Архангай, Булган аймагт БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор дэмжлэгт хяналт үнэлгээг Нэгдсэн лабораторийн албатай хамтарсан Мэргэжлийн болон Хяналтын баг бүрэлдэхүүн хийж гүйцэтгэсэн. Аймаг тус бүрийн үйл ажиллагаанд үнэлэлт өгч, цаашид анхаарах асуудал, засах шаардлагатай ажлуудыг нарийвчлан гарган удирдлагаар хэлэлцүүлэн, гарсан | | Сонгогдсон нэгжид дэмжлэгт хяналтыг зохион байгуулж, зөвлөмжийг хүргүүлсэн байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөвлөмжийг хүргүүлж ажилласан.<br><br>Дархлаажуулалтын албанаас аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдэд дархлаажуулалтын чиглэлээр дараах танхимын болон ажлын байрны сургалт, дэмжлэгт хяналтыг зохион байгуулсан байна. Үүнд:<br><br>- Эрүүл мэндийн сайдын Сүхбаатар аймагт бүртгэгдсэн ДДУХ-ын тохиолдлын хариу арга хэмжээний багт 2 албаны эмч томилогдон ажиллаж, тандалт судалгаа, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.<br>- ISO 9001:2015 сургалтад албаны 4 эмч хамрагдсан.<br>- 21 аймаг 9 дүүрэгт алсын зайн хэмийн хяналтын тоног төхөөрөмж суурилуулах сургалтыг 35 хүнийг хамруулан зохион байгуулсан.<br>- Гааль, Татвар, Санхүүгийн мэдээллийн технологийн төвийн мэргэжилтнүүдтэй цахим бүртгэлийн програмын хөгжүүлэлтийн талаарх уулзалтуудыг зохион байгуулсан.<br>- Эрсдлийн харилцаа холбоо, сэтгэл зүйн анхны тусламж үзүүлэх сургагч багш бэлтгэх сургалтыг Монголын Улаан загалмай нийгэмлэгтэй хамтран 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр 60 хүнийг хамруулан зохион байгууллаа.<br>- Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан улаанбурхан өвчний нөхцөл байдал, тандалт, хэрэгжүүлэх арга хэмжээ, дэгдэлтийн үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр цахим сургалтанд аймаг, дүүргийн өрх, | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сумын эрүүл мэндийн төвийн эмч ажилтанууд 100 гаруй хүнд хийсэн.<br>- ЭМЯ, ХӨСҮТ, ДЭМБ хамтран “Дархлаажуулалтын хөтөлбөрийн хэрэгжилт, улаанбурхан, улаанууд өвчний тандалт, хариу арга хэмжээ” сэдэвт сургалтыг 2023 оны 4 сарын 19-нд зохион байгуулсан. Сургалтанд 21 аймаг, 9 дүүргийн эрүүл мэндийн газрын нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга, дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн, халдвар судлаач, нэгдсэн эмнэлгийн чанарын менежер, хүүхдийн эмч, төрөлжсөн эмнэлэг, нийслэлийн хувийн хэвшлийн хүүхдийн эмнэлгүүдийн төлөөлөл нийт 240 хүн хамрагдсан байна.<br>- ЭМЯ, ХӨСҮТ, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Дархлаажуулалтын хөтөлбөрт гео орон зайн мэдээлэл болон гео технологи ашиглах нь” сэдэвт сургалтыг 4 сарын 20-21 өдрүүдэд зохион байгуулсан. НҮБХС-ийн GIS geo-enabling буюу эрүүл мэндийн мэдээлэлд орон зайн өгөгдөл мэдээлэл технологийг ашиглах чиглэлээр ажилладаг зөвлөх Steeve Ebener-тай хамтран зохион байгуулсан. Сургалтанд 21 аймаг, 9 дүүргийн эрүүл мэндийн газрын нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга, дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн, АШУИС-ийн багш, НЭМҮТ-ийн мэргэжилтэн, бусад байгууллагын нийт 80 хүн хамрагдсан.<br>- Олон улсын сувилагчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны хүрээнд ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын алба, | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сувилахуйн алба хамтран “Зонхилон тохиолдох халдварт өвчний сувилахуйн тусламж үйлчилгээ, тархвар судлалын вакцинжуулалт” сэдэвт сургалт, эрдэм шинжилгээний хурлыг 2023 оны 05 сарын 17-18–ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтанд 21 аймаг, 9 дүүргийн ЭМГ-ын вакцины хүйтэн хэлхээ хариуцсан бага эмч, нэгдсэн эмнэлгийн халдварт, яаралтай тусламжийн тасаг болон ХӨСҮТ-ийн сувилагч нар нийт 180 гаруй хүн хамрагдлаа.<br>- ХӨСҮТ-ийн Сувилахуйн эрдмийн чуулган-23 эрдэм шинжилгээний хуралд ХӨСҮТ-ийн 10 сувилагч, тусгай мэргэжилтэн илтгэл хэлэлцүүлж, 1-р байранд “Унах эрсдэлтэй эмчлүүлэгчийн үнэлгээ, эрсдлээс сэргийлэх арга хэмжээг боловсронгуй болгох нь” сэдвээр Ж.Уламбаяр, ХӨСҮТ-ийн ОЭДС 1-р тасгийн сувилагч, 2-р байранд “Уян зүүний гепаринтай тагийн хэрэглээний талаарх харьцуулсан судалгаа” сэдвээр Ж. Сувдмаа, ХӨСҮТ-ийн НХЦГ 5-р тасгийн сувилагч, 3-р байранд “ХӨСҮТ-ийн сүрьеэгийн лавлах лабораторийн xpert mtb/rif шинжилгээний гүйцэтгэлд хийсэн үнэлгээний дүн” сэдвээр Н. Амаржаргал, СТСА-ны лабораторийн техникч нар тус тус шалгарлаа.<br>- “Халдварт өвчин ба эрсдэлийн харилцаа холбоо” сэдэвт нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн цэцэрлэг, ЕБС-ийн эмч, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт зриулсан цахим сургалтад “Тарилгаар сэргийлэгддэг халдварт өвчин ба дархлаажуулалт” сэдвээр | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 618 хүнд мэдээлэл хийсэн.<br>- Баян-Өлгий аймагт “Тарилгатай халдварт өвчний тандалт”, “Вакцин менежмент”, “Коронавируст халдвар (ковид-19)-ын эсрэг вакцины дархлаажуулалт” сэдэвт сургалт, дэмжлэгт хяналт, мэдээ, мэдээллийн чанарт үнэлгээ хийсэн.<br>- Эрүүл мэндийн дэд сайдын баталсан удирдамжийн дагуу “улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт хийх” чиглэлээр Сэлэнгэ, Дорноговь аймагт ЭМЯ, ХӨСҮТ, ДЭМБ-ын хамтарсан баг 2023 оны 4-5 сард ажилласан. Дэмжлэгт хяналт, сургалтыг аймаг орон нутгын эмч мэргэжилтэнүүдийг хамруулан зохион байгууллаа.<br>- “Улаанбурхан өвчнөөс хамтдаа сэргийлье” уриан дор улаанбурхан, улаануud өвчний эсрэг вакцинаар нэмэлт дархлаажуулалт, дархлаажуулалтын 10 хоног зохион байгуулахтай холбоотой бэлтгэл ажил хангах хүрээнд “Улаанбурхан өвчнөөс хамтдаа сэргийлье нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулах” арга зүйн сургалтыг 2023.05.26-ны өдөр аймаг, дүүрэг, өрх, сумын эрүүл мэндийн төвийн 1000 гаруй эмч, мэргэжилтнүүдийг хамруулан цахим сургалтыг хийсэн.<br>- Вакцинатор сувилагч нарын мэргэшүүлэх сургалтад хамрагдаж байгаа сувилагч нарыг нэмэлт дархлаажуулалт зохион байгуулах тухай арга зүйн сургалтанд хамруулж, өөрсдийн орон нутагт нь дадлага хийлгэж байна.<br>- Дархан-Уул аймгийн ЭМГ, Сэлэнгэ аймгийн ЭМГ-ын шинэ мэргэжилтэнд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тандалт, вакцин менежментийн чиглэлээр мэдээлэл өгч, анхаарах асуудал, мэргэжил аргазүйгээр ханган дагалдуулан сургав.<br>- Улаанбурхан өвчний нэмэлт дархлаажуулалт зохион байгуулсантай холбоотойгоор дэмжлэгт хяналтыг 464 дархлаажуулалтын нэгж, түргэвчилсэн үнэлгээг 277 дархлаажуулалтын нэгжид тус тус хийсэн байна.<br>- Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй “Тарилгатай халдварт өвчин ба ДДУХ-ийн тандалт” бүсчилсэн сургалтыг 5 аймагт, ЭМГ-ын НЭМО дарга, Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн, Хүйтэн хэлхээ хариуцсан бага эмч, Чанарын менежер, Хүүхдийн зохицуулах мэргэжилтэн, Мэдрэлийн эмч, Мэс заслын эмч, Клиник лабораторийн эмч нарыг хамруулан зохион байгуулсан.<br>- Олон улсын улаанзагалмай нийгэмлэгтэй хамтран “Олон нийттэй харилцах, ил тод байдал ба дархлаажуулалт” сэдэвт Зүүн, Өмнөд болон Нийслэлийн бүсийн дунд шатны хороодын дарга, дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн нарыг оролцуулсан 24 хүний бүрэлдэхүүнтэй сургалтыг зохион байгуулсан.<br><br>2023 оны хяналт шинжилгээ үнэлгээний жилийн ажлын төлөвлөгөө гарган батлуулан ажиллаж байна.<br>Тус төлөвлөгөөний дагуу сүрьеэгийн 33 нэгжид (21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүрэг, Хорих 429-р анги, Энэрэл эмнэлэг, СЭМҮТ) дэмжлэгт хяналт хийж, шалгах хуудсаар үнэлгээ, зөвлөмж өгч, мэргэжил | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | аргазүйгээр ханган ажилласан.<br><br>2023 онд 19 сумын эрүүл мэндийн төв, аймгийн төвийн 8 ӨЭМТ, УБ хотын 6 дүүргийн 32 ӨЭМТ-д дэмжлэгт хяналт хийж, мэргэжил аргазүйгээр ханган ажиллаж, нийт 59 анхан шатны эрүүл мэндийн байгууллагад хүрч ажилласан.<br><br>Сүрьеэгийн эмч, мэргэжилтэнгүүдэд хамтын ажиллагаа сайжруулах цахим болон танхимаар 6 удаагийн уулзалт, ханган нийлүүлэлт, дүрс оношилгооны эмч нарыг дадлагажуулах, Сүрьеэ болон ХДХВ-ын хавсарсан халдвар, сүрьеэг оношлох молекул биологийн шинжилгээ, тубис цахим систем зэрэг сэдвүүдээр 12 удаагийн сургалт, олон улсын хурал 1-ийг зохион байгуулж, нийт давтагдсан тоогоор 692 эмч, мэргэжилтнүүдийг хамруулсан. Төслийн хүрээнд 10 эмчийг сүрьеэгийн нарийн мэргэшлийн сургалтад хамруулсан.<br><br>Найрамдах Солонгос Улсын эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо, сүрьеэгийн оношилгоо, урьдчилан сэргийлэлт; тандалт; эмчилгээ тусламж үйлчилгээ; халдварын сэргийлэлт хяналт, идэвхтэй илрүүлэлтийн үйл ажиллагаа, санхүүжилтийн механизм, нийтийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн тусламж үйлчилгээ, бэлэн байдал зэрэг чиглэлээр газар дээр нь очиж туршлага судлах, танилцах, сургалтад 21 эмч мэргэжилтнүүд хамрагдсан. Солонгосын үндэсний сүрьеэгийн нийгэмлэг, дүүргийн ЭМТ, хиймэл оюун ухааны LUNIT компани, Солонгосын сүрьеэгийн эрдэм шинжилгээний хүрээлэн (KIT), QURATIS Inc байгууллага (вакцин үйлдвэрлэл, хөгжүүлэлт), Масан үндэсний сүрьеэгийн эмнэлэг, Солонгосын үндэсний сүрьеэгийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нийгэмлэгийн Улсан-Гённам дахь салбар зэрэг байгууллагуудад зочлон харилцан илтгэл тавьж, асуулт хариулттайгаар туршлага солилцон ажилласан. | | |
| **4.12** | Сувилахуйн эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулна. | 2.5 сая төгрөг (Дотоод нөөц) | Илтгэлийн хураангуй | Сувилахуйн эрдмийн чуулган-2022 эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан. | Олон улсын сувилагчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны хүрээнд “Сувилахуйн эрдмийн чуулган 23” эрдэм шинжилгээний хурлыг 2023 оны 05 сарын 18-ны өдөр зохион байгууллаа.<br>Хуралд 21 аймаг, 9 дүүргийн ЭМГ-ын вакцины хүйтэн хэлхээ хариуцсан бага эмч, нэгдсэн эмнэлгийн халдварт, яаралтай тусламжийн тасаг болон ХӨСҮТ-ийн сувилагч нар нийт 181 хүн хамрагдлаа.<br>✅Эрдэм шинжилгээний хуралд ХӨСҮТ-ийн 10 сувилагч, тусгай мэргэжилтэн илтгэл хэлэлцүүлж:<br>✅1-р байранд “Унах эрсдэлтэй эмчлүүлэгчийн үнэлгээ, эрсдлээс сэргийлэх арга хэмжээг боловсронгуй болгох нь” сэдвээр Ж.Уламбаяр, ХӨСҮТ-ийн ОЭДС 1-р тасгийн сувилагч<br>✅2-р байранд “Уян зүүний гепаринтай тагийн хэрэглээний талаарх харьцуулсан судалгаа” сэдвээр Ж. Сувдмаа, ХӨСҮТ-ийн НХЦГ 5-р тасгийн сувилагч<br>✅3-р байранд “ХӨСҮТ-ийн сүрьеэгийн лавлах лабораторийн xpert mtb/rif шинжилгээний гүйцэтгэлд хийсэн үнэлгээний дүн” сэдвээр Н. Амаржаргал, СТСА-ны лабораторийн техникч<br>Тусгай байранд “Сүрьеэ болон чихрийн шижин өвчин хавсарсан оноштой эмчлүүлэгчдийн өөрийгөө хянах мэдлэгийг үнэлэх, дээшлүүлэхэд сувилагчийн оролцоо” сэдвээр А. Болортуяа, ОЭДС 2-р тасгийн ахлах сувилагч нар тус тус шалгарлаа.<br>✅Эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлсэн судалгааны ажлууд нь ХӨСҮТ төдийгүй бусад эмнэлгийн | 100% | Сувилахуйн эрдмийн чуулган 2023-ыг зохион байгуулж, илтгэлийн хураангуй хэвлүүлсэн байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сувилахуйн тусламж үйлчилгээг сайжруулахад нотолгоо болохуйц үр ашигтай бүтээлүүд байсан тул нийт судлаач нартаа халуун баяр хүргэж цаашдын судалгааны ажилд нь өндөр амжилт хүсье.<br>✅ХӨСҮТ-ийн Сувилахуйн эрдмийн чуулган-23 арга хэмжээний шүүгчээр ХӨСҮТ-ийн Эрдэм шинжилгээ судалгаа эрхэлсэн дэд захирал НЭМУ-ны магистр О.Батбаяр, Яаралтай тусламжийн тасгийн их эмч Анагаах ухааны доктор Б.Батсүх, Юниверсал мед эмнэлгийн захирлын ажлын албаны дарга, СУ-ны доктор Г.Дэлгэрсүрэн нар ажиллалаа. | | |
| **4.13** | Томуугийн үндэсний зөвлөгөөнийг зохион байгуулна. | 77 сая төгрөг (Төсөл, хөтөлбөрийн хүрээнд) | Зөвлөгөөний тайлан | Жил бүр зохион байгуулдаг. | Томуугийн харуулдан тандалтын нэгжүүдийн 10 дах удаагийн уулзалт, зөвлөгөөн 2023 оны 11 дүгээр сарын 01, 02-ны өдрүүдэд “Миллениум плаза” зочид буудлын хурлын танхимд зохион байгуулсан. Зөвлөгөөнд 21 аймаг, 9 дүүргийн ЭМГ, ЭМТ, НЭ, БОЭТ, өрх, сумын ЭМТ болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга, захирал, тархвар судлагч вирус судлагч эмч гэх мэт нийт 180 гаруй мэргэжилтнүүд оролцож өнгөрөгч томуугийн улиралд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ололттой болон сул талын талаар хэлэлцүүлэг өрнүүлж, цаашдын үйл ажиллагааны чиглэлийг хамтран гаргалаа. Мөн уулзалт, зөвлөгөөнд эрүүл мэндийн салбарын тэргүүлэх эмч, эрдэмтэн, судлаачид оролцож олон сонирхолтой нийт 24 илтгэл тавьж хэлэлцүүлсэн. Уулзалт зөвлөгөөнөөс зөвлөмж гарган харуулдан тандалтын нэгжүүдэд төвийн ерөнхий захирлын албан тоотоор хүргүүлсэн | 100% | Зөвлөгөөн зохион байгуулж, гарсан зөвлөмжийг холбогдох байгууллагуу дад хүргүүлсэн байна. |
| **4.14** | КОВИД-19-ийн эсрэг зөвшөөрөгдсөн вакцины эмнэлзүйн туршилт (UB612-501) | 643.6 сая төгрөг (Олон улсын байгууллага) | Судалгааны үр дүн, хэвлэгдсэн нийтлэл | - | “18-аас дээш насны насанд хүрэгсдийн дунд Ковид-19-ийн эсрэг зөвшөөрөгдсөн вакцины гомолог сэргээх тун ба UB-612 вакцины гетеролог сэргээх тунгийн | 80% | Нийт 135 оролцочийг эмнэлзүйн туршилт |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | судалгаа хийнэ. | | | | аюулгүй байдал, хүлцэх байдал болон дархлал тогтоцыг харьцуулах, санамсаргүй түүвэрлэлт, идэвхтэй хяналт бүхий Монгол дах судалгаа" (UB612-501)-ны мэдээ материал цуглуулж, үр дүнгийн боловсруулалт хийн ажиллаж байна. | | судалгаанд хамруулж, үр дүнг олон улсын сэтгүүлд нийтлүүлсэн байна. |
| **4.15** | Вакцины дархлал тогтоцын түвшинг үнэлэх лабораторид суурилсан тандалт судалгаа хийнэ. | Улсын төсөв, Олон улсын төсөл, хөтөлбөр | Гүйцэтгэлийн хувь | - | Вакцины дархлал тогтоцын түвшинг үнэлэх лабораторид суурилсан тандалт судалгааг хийхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 20% | Тандалтын судалгааны гүйцэтгэл 30 хувьд хүрсэн байна. |
| **4.16** | Ретровирусын эсрэг хэрэглэгдэж буй эмэнд судалгаа хийнэ. | Дотоод нөөц | Судалгааны үр дүн | - | "ХДХВ-ийн халдвартай үйлчлүүлэгч, ӨӨУСЭ, ӨДУСЭ-ний ретровирусийн эсрэг эмийн зардлыг тооцох" судалгааг тус төвийн ДОХ/БЗДХ-ын тандалт сэргийлэлтийн албаны хяналтанд байгаа 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс 2023 оны 11 дүгээр сарын 06-г хүртэлх хугацаанд эмчилгээнд хамрагдсан ХДХВ-тэй амьдарч буй хүмүүс болон ӨӨУСЭ, ӨДУСЭ-ний эмийн зарцуулалтын хуудсыг ашиглан эмийн хэрэглээ, зарцуулалтанд боловсруулалт хийсэн. Судалгааны хугацаанд ДОХ/БЗДХ-ын ТСА-ны хяналтын 267 үйлчлүүлэгч 1-3 сарын давтамжтай эмчилгээнд хамрагдсан, 124 эрүүл мэндийн байгууллагат ӨДУСЭ, 2023 онд ӨӨУСЭ-гээг олгоогүй бөгөөд 2022 онд ӨӨУСЭ-гээг 150 орчим үйлчлүүлэгчид олгосон байна. 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар ДОХ/БЗДХ-ын ТСА РВЭЭ-нд 209.234.112 төгрөг зарцуулсан боловч ЭМД-аас санхүүжилт авч чадахгүй байгаа нь эмийн тасалдал үүсэх эрсдэл үүсч байна. | 100% | Ретровирусын эсрэг эмчилгээнд хэрэглэж байгаа эм, эмчилгээний үр дүн, зардлыг тооцон, гаж нөлөөг судалсан байна. |
| **4.17** | Томуугийн вакцины үр ашгийн талаарх судалгааг үргэлжлүүлэн хийж гүйцэтгэнэ. | Олон улсын байгууллагын дэмжлэг | Судалгааны үр дүн, хэвлэгдсэн нийтлэл | Судалгааны явц 70 хувь байна. | Улирлын томуугийн эдийн засгийн дарамтын судалгаанд 9 аймаг, 8 дүүргийн 2800 хүнээс асуумжаар судалгааг авч, Epi-info программд оруулж, дүгнэлт | 100% | Судалгааны үр дүнг олон улсын сэтгүүлд нийтлүүлсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тайланг бичсэн.<br><br>Албан бичгээр судалгаанд оролцож буй байгууллагуудаас санхүүгийн нэмэлт мэдээллийг аван нэгтгэсэн.<br><br>Даян дэлхийн эрүүл мэндийн төлөөх байгууллагаас ирүүлсэн аргачлалд өмнөх 2 жилийн мэдээллийг оруулсан.<br><br>2019-2023 онд томуугийн эдийн засгийн дарамт томуугийн вакцины өртөг зардлын үр ашигийн судалгааг хийж, нэгдсэн тайлан бичих ажил хийгдэж байна.<br><br>ДДЭМБ, АӨХТ-ийн мэргэжилтэн нартай хамтран тооцоо, дүгнэлтийг хийж байна. 3 жилийн турш хийгдсэн судалгааны урьдчилан байдлаар тайлан, дүгнэлтийг бичин хүргүүлсэн. | | байна. |
| **4.18** | Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар үүсгэж буй бичил биетний тэсвэржилтийн байдалд тандалт судалгаа хийнэ. | Олон улсын байгууллагын дэмжлэг | Судалгааны үр дүн | - | 2022-2023 онд тус төв нь сонгосон 4 төрөл ЭТҮХХ–ыг ЭМС-ийн А/539 дугаар тушаалаар батлагдсан тандалтын зааврын дагуу тандах зорилгоор харуулдан тандалтын 15 нэгжийг сонгож, илрүүлэг тандалт хийх багийн нийт (n=238) ажилтныг ажлын байранд нь сургаж мэргэжил арга зүйгээр хангасан.<br><br>Сонгосон харуулдан тандалтын 15 нэгжээс ирж буй (МЗДШХ), (ШХШЗХ), (СГХХ), (ЗААХУХ ) бүхий халдварын сэжигтэй, батлагдсан тохиолдлын мэдээ болон халдвар үүсгэгч бичил биетний тэсвэржилтийн байдалд тандалт судалгааг хийж сар бүр эргэн мэдээллээр хангаж ажиллаж байна.<br><br>2023 оны эхний 11 дүгээр сарын байдлаар ЭТҮХХ-ын 279 тохиолдол батлагдсны 33% | 100% | Бичил биетний тэсвэржилтийн түвшинг тогтоосон байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нь харуулдан тандалтын нэгжээс мэдээлэгдсэн байна. Харуулдан тандалтын нэгжид нийт 176 199 ажилбарт халдварын шинж тэмдгийн тандалт хийсэн байна. ЭТҮХХ-ын 92 тохиолдол бүртгэгдсэний 91%-д нян судлалын шинжилгээ хийгдсэн. Шинжилгээнд илэрсэн үүсгэгчийн нянгийн тэсвэржилтийн байдалд тандалт судалгаа хийсэн. | | |
| **4.19** | Сонгогдсон дархлаажуулалтын нэгжийн товлолын дархлаажуулалтын хамралт, вакцины хадгалалт тээвэрлэлтийн хэмийн хяналтын үнэлгээ хийнэ. | 300 сая төгрөг (Олон улсын байгууллага) | Үнэлгээ, судалгааны үр дүн | Сар, улирал, жилээр хамралтын тайлан мэдээ нэгтгэж, хяналт хийсэн. | Сонгогдсон дархлаажуулалтын нэгжийн товлолын дархлаажуулалтын хамралтын тоон судалгаа эхний аймгуудаас тоон мэдээ цуглуулалт хийгдэж байна. Төсвийн санхүүжилтээр вакцины хадгалалт тээвэрлэлтийн хэмийн хяналтын үнэлгээ хийх үндэслэлийг бичиж өгсөн. | 40% | Товлолт дархлаажуулалтын мэдээлэгдсэн хамралтын судалгаа, хадгалалт, тээвэрлэлтийн хэмийн хяналтын үнэлгээг хийсэн байна. |
| **4.20** | Солонгосын сүрьеэгийн үндэсний нийгэмлэгтэй хамтарсан “Сүрьеэгийн хавьтлын хяналтыг сайжруулах нь” төслийг хэрэгжүүлнэ. | 950 сая төгрөг (Солонгосын сүрьеэгийн үндэсний нийгэмлэг, Койка) | Үзлэгт хамрагдсан хавьтлын тоо | 2022 онд 4600 хавьтлыг үзлэг шинжилгээнд хамруулсан. | 2023 онд сүрьеэтэй өвчтөний өрхийн болон ойрын хавьтлын давтан үзлэгийн хамралтыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлж байна. СҮСН-тэй хамтран “Сүрьеэгийн хавьтлын илрүүлэлт, хяналтыг сайжруулах нь” төслийг Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт хэрэгжүүлж, энэ онд явуулын баг сүрьеэтэй өвчтөний өрхийн хавьтлын 6721 хүнийг идэвхтэй үзлэг шинжилгээнд хамруулж, үүнээс сүрьеэгийн сэжигтэй 537 хүнээс (8.0%)-д нь цэрний сорьц цуглуулсан байна. Үүнээс идэвхтэй хэлбэрийн сүрьеэтэй 127 тохиолдлыг илрүүлж, харьяа дүүргийн диспансерийн хяналтад эмчилгээнд оруулсан байна.<br>Нийт 6721 хавьтлаас 4409 нь буюу 65.6% нь давтан үзлэг шинжилгээнд хамрагдсан байна. | 100% | 2023 онд нийт хавьтлыг үзлэг шинжилгээнд бүрэн хамруулсан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Давтан үзлэг шинжилгээнд хамрагдсан хавьтлаас 54 хүн сүрьеэгээр өвчилсөн нь илэрч, эмчилгээнд хамруулсан байна.<br>Хиймэл оюун ухаанд суурилсан зөөврийн дижитал рентген аппарат бүхий гэрийн үзлэгийн баг хэвтрийн, хөгжлийн бэрхшээлтэй, нэн ядуу, унааны мөнгөгүй, сэтгэцийн эмгэгтэй, өндөр настай зэрэг, асрамжинд байдаг 1805 хүнийг гэрт нь очиж үзлэгт хамруулж 126 хүнээс цэрний сорьц цуглуулж, сүрьеэтэй 8 хүнийг илрүүлэн эмчилгээнд хамруулсан байна. | | |
| **4.21** | Сүрьеэ өвчний улмаас нас барсан өвчтөнүүдийн шалтгаан хамаарлын судалгааг хийнэ. | Дотоод нөөц | Судалгааны тайлан | - | Тус төвийн хэмжээнд 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 103 нас баралт бүртгэгдсэн бөгөөд 2022 оны мөн үеийнхтэй харьцуулахад 55 тохиолдол буюу 34.8%-иар буурсан үзүүлэлттэй байна.<br>Хоног болоогүй нас баралт-11 (10.6%). Хоног болоогүй нас баралт өмнөх онтой харьцуулахад 3 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.<br>Эмгэг судлалын шинжилгээнд орсон тохиолдол - 52 (90,9%)<br>Оношийн зөрөө гараагүй.<br>Онош тохирсон тохиолдол 2023 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар 52 тохиолдол бүртгэгдэж оношийн тохироо 100%-тай байна.<br>Сүрьеэгийн клиникийн нас баралт оношоор n=86<br>Сүрьеэ өвчний шалтгаант нас баралтын 75.5%-ийг эрэгтэйчүүд эзэлж байна.<br><br>Сүрьеэгийн шалтгаант нас баралт 50-59 насанд хамгийн их 25 тохиолдол буюу (29%)-ыг эзэлж байна. Сүрьеэгийн шалтгаант нас баралтын 19 (22%) - д архаг архисах өвчин хамгийн их хувийг эзэлж байна. 20.9% нь эмээ тасалсан тохиолдол эзэлж байна. 23.2% нь хөдөө орон нутгийн харъяалалтай | 100% | Сүрьеэ өвчний нас баралтад нөлөөлж буй шалтгаан хамаарлыг тодруулсан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлчлүүлэгчид байна. | | |
| **ЗОРИЛТ 5. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ ДЭМЖИХ** | | | | | | | |
| **5.1** | Эрүүл мэндийн ажилчдын нийгмийн хамгааллыг дэмжих арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлнэ. | Дотоод нөөц | Хэрэгжилтийн хувь | 2022 онд нийгмийн хамгааллыг дэмжиж 9 ажилтанд орон сууцны урьдчилгаа 180 сая төгрөг олгосон. | Нэг удаагийн буцалтгүй тэтгэмж 26 ажилтанд, цалинтай чөлөө 76 ажилтанд тус тус олгосон байна. "Мед лиг" Монголын Эрүүл мэндийн салбарын анхны сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон нийт тэмирчдад урамшуулал олгосон | 100% | Төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсэн байна. |
| **5.2** | Нийт албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлнэ. | - | Цаг ашиглалтын хувь | Тогтмол биш | 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Төвийн үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан хамтын гэрээний 3 дугаар бүлгийн 3.9, 3.34 дэх заалт, 4 дүгээр бүлгийн 4.1, 4.4, 4.6, 4.12, 8 дугаар бүлгийн 8.4 дэх заалтаар нийт албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулж, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх заалтууд тусган хэрэгжүүлж ажиллаж байна. | 100% | Ажлын цаг ашиглалт сайжирсан байна. |
| **5.3** | Албан хаагчдын урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулна. | Дотоод нөөц | Үзлэгт хамрагдсан албан хаагчдын хувь | 2021-2022 онд урьдчилан сэргийлэх үзлэг хийгдээгүй. | Ерөнхий захирлын 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/55 дугаар тушаалын дагуу 2023 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулахаар төлөвлөгөө гарган ажилласнаас байгууллага дээр 34%, харьяалалын дагуу эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан ажилчид 17% хамрагдсан байна.<br>**Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг зохион байгуулах үйл явц:**<br>Тус төвийн албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах хуваарийг гарган эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний багцад хамаарах насны ангиллаар нэмэлт үзлэг, шинжилгээг албан хаагч тус бүрээр хамруулсан. | 75,5% | ХӨСҮТ-ийн нийт албан хаагчдыг 90-ээс дээш хувийг хамруулсан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Ажилчдын 712 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. | | |
| **5.4** | Яаралтай тусламжийн суурь болон лавшруулсан тусламж үйлчилгээний сургалтад эмч, ажилчдыг үе шаттай хамруулна. | Дотоод нөөц | Сургалтад хамрагдсан ажилтны эзлэх хувь | 2021-2022 онд сургалтад яаралтай тусламжийн эмч, ажилчдыг хамруулсан. | Сүрьеэгийн яаралтай тусламжийн тасгийн их эмч нар, Шинэ болон дахин сэргэж буй халдварын 7-р тасгийн их эмч нар, Уушгины 2 дугаар тасгийн их эмч нарыг Яаралтай тусламжийн суурь болон лавшруулсан тусламж үйлчилгээний 6 сарын сургалтад хамруулан суралцаж байна. | 100% | Төвийн нийт эмч, сувилагч, асрагч нарыг бүрэн хамруулсан байна. |
| **5.5** | Хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй үйлчлүүлэгчдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх ажилтан бэлтгэнэ. | Дотоод нөөц | Сургалтад хамрагдсан гэрчилгээ | Бэлтгэгдсэн ажилтан байхгүй. | Амбулаторийн хөтөч сувилагч нарыг хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй үйлчлүүлэгчдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх ажилтнаар сургаж бэлдсэн. | 100% | Нийт 2 ажилтан сургаж, бэлтгэсэн байна. |
| **ЗОРИЛТ 6. ЭРҮҮЛ МЭНДИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ, ГҮЙЦЭТГЭЛД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙГ ҮР АШИГТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ** | | | | | | | |
| **6.1** | Сүрьеэгийн эмнэлэг байгуулна. | Улсын төсөв | Барилгын угсралтын хувь | - | Шүүхийн маргаантай. ТХААГ-аас худалдан авах ажиллагааг зохион байгуулж, “Хар чонот” ХХК-тай гэрээ байгуулах зөвлөмж ирүүлсэн. Тус компани нь Сангийн сайдын 2021 оны тушаалаар “хар жагсаалт” буюу тендерт оролцох эрхгүй ААНБ-ын жагсаалтад орсон тул гэрээ байгуулах боломжгүй тухай албан бичгийг ТХААГ-т хүргүүлсэн. ХАА-г дахин зарласан боловч “Хар чонот” ХХК шүүхэд гомдол гаргасан тул ХАА зогссон. Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх хуралдаанд нэхэмжлэгч "Хар чонот" ХХК ялагдсан ба дараагийн шатны шүүх хуралдааны шийдвэрийг хүлээж байна. | 0% | Барилгын ажлыг эхлүүлж, угсралтыг 30 хувьд хүргэнэ. |
| **6.2** | ХӨСҮТ-ийн 2023-2026 оны стратеги төлөвлөгөөг батлуулна. | - | Шинээр батлагдсан стратеги төлөвлөгөө | - | Тус төвийн 2023-2026 оны стратеги төлөвлөгөө боловсруулагсан бөгөөд ЭМЯ-нд хянуулах шатанд байна. | 70% | Стратеги төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлж эхэлсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байна |
| **6.3** | Тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн нэр төрлийг тодорхойлох, нэгжийн өртгийг тооцож, өртгийн жинг онош тус бүрээр нэмэгдүүлэх арга хэмжээ авна. | Дотоод нөөц | Тусламж, үйлчилгээг нэр төрлөөр тооцсон өртөг, санхүүжилтийн хэмжээ | Гүйцэтгэлийн санхүүжилт нь 2021 оны 3 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн. | Хэвтүүлэн эмчлэх сүрьеэгийн 4, мэс заслын тусламж, үйлчилгээний 6, эрчимт эмчилгээний 2, хөнгөвчлөх эмчилгээний 1, амбулаторийн тусламж, үйлчилгээний 1, өндөр өртөгт тусламж, үйлчилгээ, түргэн тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээний тусламж, үйлчилгээний нийт 16 оношийн хамаарлын бүлгийн өртгийн тооцоолол тус бүр дээр 50 өвчний түүхээр хийж ЭМДЕГ-т төвийн захирлын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 3-7-1/175 тоот албан бичгээр хүргүүлсэн ба өртгийн тооцоолол ЭМДЕГ-т хийгдсэн.Төвийн захирлын 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 3-7-1/604 тоот албан бичгээр 5 тусламж, үйлчилгээний нэр төрлөөр 33 оношийн хамаарлын бүлэг тус бүрийн нэхэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн саналыг хүргүүлсэн ба салбар зөвлөлийн ажлын хэсэг Халдварт өвчний оношийн бүлгийн нэхэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн өөрчлөлтийг хийж хүргүүлсэн.<br>Халдварт өвчний оноштой хэвтэн эмчлүүлэгч, яаралтай мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлэх иргэдийн тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаатай холбогдуулан тусламж үйлчилгээгээ өргөжүүлэн, ЭМДЕГазартай байгуулсан гэрээнд оношийн бүлгийг нэмэлтээр оруулах албан бичиг хүргүүлж мэс заслын тусламж үйлчилгээний 122 оношийн хамаарлын бүлгийг тусгуулж, төвийн хэмжээнд 214 оношийн хамааралтай бүлэг, 12-13 нэр төрлийн тусламж үйлчилгээ үзүүлж, гүйцэтгэлийг хангаж ажилсан. | 95% | A00-B99 оношийн бүлгийн өртгийн жинг нэмэгдүүлсэн байна. |
| **6.4** | Тусламж, үйлчилгээний санхүүжилтийн нэхэмжилсэн дүнгээс хасагдлын хувийг | Дотоод нөөц | Хасагдлын хувь | 2022 оны нэхэмжилсэн дүнгээс хасагдлын хэмжээ 13 хувь, дундаж 11 хувь | 2023 оны 10 сарын байдлаар 18,733,340 төгрөгийн нэхэмжлэл ЭМДЕГ-т хүргүүлж 17,300,050 төгрөг авсан ба 1,433,280 төгрөг хасагдаж, хасагдлын хувь 8 байна. Үүнд: Нэхэмжлэлийн шалгуур үзүүлэлт хангаагүй /эмнэлзүйн шалтгаантай/ | 100% | 2023 оны нэхэмжилсэн дүнгээс хасагдлын хэмжээг 5 хувьд |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бууруулна. | | | байсан. | 1,151,424 төгрөг буюу 6%, цахим хяналтаар 281,863,880 төгрөг буюу 1,5% нь тус тус хасагдсан байна. Хасагдсан хувь өмнөх оны мөн үеэс 5%-иар буурсан байна. Хасагдлын хувийг бууруулахын тулд эмч мэргэжилтнүүдээ чадавхижуулж, ЭМДҮЗ-ийн 2023 оны 08 дугаар тогтоолын дагуу эмч мэргэжилтнүүдэд ЭМДЕГазрын мэргэжилтнүүд болон хөгжүүлэгч компаний мэргэжилтнүүдийг авчирч 4 удаагийн сургалт хийлээ. Нэхэмжлэлийн хяналтыг тусламж үйлчилгээ тус бүр дээр хийж, амбулатори, стационар, яаралтай тусламж үйлчилгээ болон клиник биохимийн лабораториудад хийгддэг шинжилгээнүүдийг нэхэмжилэхэд алдаа үүсч, дутуу нэхэмжлэгдэж байгаа бүх үйлчилгээг өдөр бүр хянаж, нэг бүрчлэн нөхөж нэхэмжилж, цахим хасагдлын шалтгааныг судлан, арилгаснаар цахим хасагдал 1,4%, эмнэл зүйн хасагдал 5,6% болж, 2022 онд нэхэмжлэлийн хасагдлын хувь 13% байсан бол 2023 онд 13 нэр төрлийн тусламж үйлчилгээнд 20,5 тэрбум төгрөгийн нэхэмжлэл илгээж, нийт хасагдлыг 5 хувиар бууруулж 7% болголоо. | | хүргэсэн байна. |
| **6.5** | Элэгдлийн хугацаа дууссан, үлдэх өртөггүй болсон ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийг акталж устгана. | Дотоод нөөц | Акталсан үндсэн хөрөнгийн тоо, үнийн дүн | 2022 онд ЭМЯ, ТӨХ-нд Үндсэн хөрөнгийн актлах хүсэлт хүргүүлсэн боловч шийдвэрлээгүй. | Элэгдлийн хугацаа дууссан, үлдэх өртөггүй болсон ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийн жагсаалтыг ЭМЯам, ТӨХороо, ЭЭХХЗГазарлуу үндсэн хөрөнгийг актлуулах хүсэлтээ хүргүүлсэн. ТӨБЗГазрын А/537, А/632, А/635 тоот тогтоолоор актлах болон балансад шилжүүлэх хөрөнгийг жагсаалт ирж төвийн Өмч хамгаалах байнгын зөвлөл хэлэлцэн даснаас хасах шийдвэр гаргасан.<br><br>Балансаас балансад шилжүүлсэн тээврийн хэрэгсэл-3ш<br>Дүн 90.0 сая<br>Актласан хөрөнгө-1341ш | 100% | Үндсэн хөрөнгийн үр ашиггүй үнэлгээ багасч, бодит тайлан гарсан байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Дүн 711.8 сая | | |
| **6.6** | Төвийн хэмжээнд үндсэн хөрөнгийг бар коджуулна. | Дотоод нөөц | Коджуулсан үндсэн хөрөнгийн тоо, үнийн дүн | Урьд нь хийгдэж байгаагүй. | Си ти эс ХХК-ний онлайн программ хэрэглэдэг бөгөөд уг компанид үндсэн хөрөнгө бар коджуулахад шаардлагатай программ уншигч суулгуулах санал тавьсан. | 50% | Үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хяналт сайжирсан байна. |
| **6.7** | Халдвартын клиникийн сэхээн амьдруулах эрчимт эмчилгээний тасаг, Мэс заслын тасгийн дээвэр /3Б байр/-ийн их засварын ажлыг гүйцэтгэнэ. | 250 сая төгрөг (Дотоод нөөц) | Их засварын ажлын гүйцэтгэлийн хувь | 1986 оноос хойш их болон урсгал засвар хийгдэж байгаагүй. | Сэхээн амьдруулах эрчимт эмчилгээний тасгийн дээврийн их засвар болон Физик эмчилгээний дээврийн их засварыг гүйцэтгүүлэх худалдан авах ажиллагааг зохион байгуулж АГ/23/91 дүгээр гэрээний дагуу 226,517.3 мянган төгрөгөөр 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр 100% хүлээн авч бүрэн ашиглалтанд оруулсан. | 100% | Их засварыг ажлыг бүрэн гүйцэтгүүлж, ашиглалтад хүлээн авсан байна. |
| **6.8** | Хурлын танхимд зориулалтын тоног төхөөрөмж суурилуулна. | 400 сая төгрөг (Дотоод нөөц) | Тоног төхөөрөмжийн тоо | Хурлын заал нь үйл ажиллагаа явуулахад зориулалтын бус тоног төхөөрөмжтэй. | Хурлын танхимд шаардлагатай засвар үйлчилгээ болон шаардагдах тоног төхөөрмжийг гарган Барилга хот байгуулалтын яамны харьяа Барилга хөгжлийн төвөөр магадлан хийлгэн баталгаажуулж авсан.<br><br>Гүйцэтгэгч компаныг сонгон шалгаруулахад бэлэн болсон бөгөөд санхүүжилтын асуудал шийдэгдээгүй тул түр хойшилсон. | 50% | Зориулалтын тоног төхөөрөмж суурилуулсан байна. |
| **ЗОРИЛТ 7. ЦАХИМ ЭРҮҮЛ МЭНДИЙН СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ** | | | | | | | |
| **7.1** | Цахим эрүүл мэндийн төслийг бүрэн хэрэгжүүлнэ. | 20 сая төгрөг (Дотоод нөөц) | Төслийн хэрэгжилтийн хувь | Хэрэгжилтийн хувь 90 байна. | PACS систем албан ёсны эрхтэй серверийн тохиргоо хийгдэн суурилагдсан. Одоогийн байдлаар эрт илрүүлгийн эхо холбогдсон. Дүрс оношлогооны 3 төхөөрөмж холбогдоогүй байна.<br>– БЗДХ, сүрьеэгийн бүртгэлийн маягтуудыг зуруулж, кодчлолыг хийлгэсэн. Нэмэлт цэсэнд холбосон. Эмнэлэгийн цахим цаг олголтыг | 100% | Цахим эрүүл мэндийн төслийг бүрэн хэрэгжүүлсэн байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэгдсэн дуудлагын төв болон И-Монголиа платформд холбосон. Иргэд цахим системээр шинжилгээний хариуг шууд авах боломжтой болсон. Даатгалын нэхэмжлэхийн цахим хасагдалтыг бууруулах үйлчилгээ авсан. Гэрээний дугаар АГ/23/17. ehealth /цахим эрүүл мэнд програм/ хөгжүүлэгч байгууллагатай систем үйлчилгээ үзүүлэх нэмэлт гэрээ хийгдсэн. Гэрээний дугаар АГ/23/106 Цахим системийн сургалтыг танхим болон цахим хэлбэрээр 8 удаа зохион байгуулсан байна. Датабааз серверийг 2 сарын 10 нд Windows Server 2022 licensed үйлдлийн систем суулган Dell PowerEdge R740 (2xIntel Xeon Silver 4214R 2.4G, 12C24T, 4x16GB+ 4x32Gb RDIMM, 3200MTs, 10x1.2TB 10K RPM SAS үзүүлэлттэй серверийг шинээр суурилуулсан. ЭМДҮЗ-ийн 8 дугаар тогтоолын дагуу 19 модулын дагуу хөгжүүлэлт, засвар үйлчилгээ хийгдсэн. Ажлын байрны сургалтыг тогтмол хийж үйл ажиллагааны хэвийн байдлыг хангасан. | | |
| **7.2** | Мэдээлэл технологийн дэд бүтцийг хэрэглэгчийн эрхийн түвшингээр хянах, мэдээлэл, сүлжээний аюулгүй байдлыг хангана. | Дотоод нөөц | Тохиргоо хийгдсэн болон сүлжээнд холбогдсон мэдээлэл технологийн тоног төхөөрөмж | Хэрэгжилтийн хувь 90 байна. | Cisco удирдах боломжтой 64 сүлжээ салаалагч, Access point – 40, шинээр тохиргоо хийж суурилуулж дууссан. 575 хэрэглэгчийн эрхийн тохиргоо хийгдсэн.<br>Үндсэн интернэт Жи Мобайл ХХК-ны 60мб хурдтай. Гэрээний дугаар- ХАА/21/25, Нөөц интернэт Ситинет ХХК-ны 50мб хурдтай.<br>Гэрээний дугаар- АГ/23/28.<br>– Cisco албан ёсны эрхтэй сүлжээний төхөөрөмжийг байр, давхар, давхарын хэрэглэгч тус бүрээр сүлжээ ашиглалтын удирдлагын эрхийн тохиргооны лист үүсгэсэн. Fortnet 601E галт ханын сүлжээний | 100% | Cisco албан ёсны эрхтэй сүлжээний төхөөрөмжийг байр, давхар, давхрын хэрэглэгч тус бүрээр сүлжээ ашиглалтын удирдлагын эрхийн тохиргоо хийж, Fortnet 601E галт ханын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | аюулгүй байдлыг хангасан тохиргоо хийгдсэн байна. Тус төхөөрөмж дээр мэдээллийн аюц FortiAnalyzer 200E Сүлжээний дүн шинжилгээ хийгдэх боломжтой төхөөрөмж суурилуулсан, Удирдлагын тохиргоо хийгдсэн. 2019 оны ЭМС-ийн А/396 Мэдээллийн аюулгүй байдлын журам, МУ-ын Засгийн газрын 197-р тогтоол "Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулах, ашиглах журам", 5-р тогтоол “Төрийн албаны интернэтийн зохистой хэрэглээг бий болгох тухай”, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | | сүлжээний аюулгүй байдлын тохиргоонуудыг бүрэн хийж ашиглалтад оруулсан байна. |
| **7.3** | Халдварт өвчний чиглэлийн улсын хэмжээний системүүдэд үнэлгээ хийж, мэдээлэл солилцох нэгдсэн систем бүрдүүлнэ. | 160 сая төгрөг (Олон улсын байгууллага) | Шинэчлэгдсэн програм хангамж, мэдээллийн сан | Сүрьеэгийн бүртгэлийн системийн гүйцэтгэл 90 хувь, зорилтот хүн амд зориулсан програмын хэрэгцээний үнэлгээ хийх судлаачийг сонгон шалгаруулах үнэлгээний ажил 30 хувь байна. | Сүрьеэгийн бүртгэл, мэдээллийн системд ХАА/21/67 тоот гэрээний дагуу нэмэлт хөгжүүлэлт хийгдсэн.<br><br>Мөн нэмэлтээр мобайл програмын хөгжүүлэлтийн гэрээ, нэмэлт сайжруулалтын гэрээний дагуу ажлыг гүйцэтгэн гэрээг дүгнэсэн. ТЕГ-т эрсдлийн үнэлгээ хийлгэх хүсэлтийг 5 сард хүргүүлсэн. Одоогоор хариу зөвлөмж ирүүлээгүй байна.<br><br>Дархлаажуулалтын системийн 22/А32 тоот ГТМТТ-тэй хийсэн гэрээний дагуу ажлууд хийгдэж 2023.04.01-нд гэрээг дүгнэсэн.<br><br>Интернэтэд суурилсан томуугийн мэдээллийн шинэ системийг ДЭМБ, PIVI төслийн хүрээнд АГ/22/334 тоот гэрээний дагуу хийгдэж байна. Вирус судлалын тандалтын нэгдсэн системийг Даян дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр АГ/22/29 тоот гэрээний дагуу хийгдэж дууссан.<br><br>Зорилтод хүн амд зориулсан программын хэрэгцээний үнэлгээ хийгдсэн. Глобал сангийн дэмжлэгтэйгээр Эрсдэлт бүлгийн | 90% | Халдварт өвчний улсын хэмжээний мэдээлэл солилцох нэгдсэн систем бүрдүүлж мэдээллийн сантай болсон байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүн амын мэдээллийн цахим сан, программ хангамжийг шинэчлэх ажлын АГ/23/385 тоот гэрээний дагуу хийгдэж байна.<br>– Халдварт өвчний тандалтын тогтолцоог шинэчлэн өргөжүүлэх Глобал сангийн CR19 төслийн хүрээнд Халдварт өвчний мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, одоогийн цахим системийг нэгтгэх, шинэ систем нэвтрүүлэх төслийн ажлын даалгавар, техникийн шаардлага, үндэслэл гаргаж ЭМЯ-нд хүргүүлсэн. Тус төсөл нь 2024-2025 онд хэрэгжихээр батлагдсан. | | |
| **7.4** | Байгууллагын цахим хуудсыг шинэчилнэ. | 15 сая төгрөг (Дотоод нөөц) | Шинэ цахим хуудас | Wordpress open source CMC ашиглан загвар авсан. Загварчлах ажил хийгдэж байна. Цахим хуудсанд орох мэдээллийн бэлтгэл ажил хийгдэж байна. | Nccd.gov.mn цахим хуудсны 2018 оноос хойших Цэс бүрээр мэдээллийн 9 үндсэн цэс, 42 дэд цэсээр, Ил тод байдлын төсөв санхүүгийн мэдээлэл 8 цэс тус бүрээр нийт 17GB хэмжээний 805 мэдээллийг нөөцөлж авсан. Шинэ дизайн бүхий цахим хуудсыг шинэчлэх АГ/23/229 тоот гэрээг байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар хэрэгжилт 80% байна. | 80% | Шинэ дизайн бүхий цахим хуудсыг үйл ажиллагаанд бүрэн оруулсан байна. |
| 2023 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 30.1 тэрбум төгрөг (эх үүсвэр: улсын төсөв, өөрийн хөрөнгө, ДЭМБ, Глобаль сан болон Олон улсын байгууллагын санхүүжилт)-ийн төсөвт өртөг бүхий нийт 82 арга хэмжээ төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар гүйцэтгэх 51 арга хэмжээг бүрэн гүйцэтгэсэн бөгөөд үлдсэн 31 арга хэмжээний жилийн эцсийн явцын тайланг оруулав. Төлөвлөгөөний биелэлийн хувь 90 хувьтай байна. | | | | | | | |

*Төлөвлөгөөг үнэлсэн:* *Төсвийн Ерөнхийлөн захирагч*

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД** .............................. **С.ЧИНЗОРИГ**

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ..............................

*Төлөвлөгөө тайлагнасан:*

**ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ**
*(албан тушаал)*

*Төсвийн Шууд захирагч*

**...............................** **Ж.БАЙГАЛМАА**
*(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ..............................

---o0o---